



СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2024 оны 05 сарын 27 өдөр

Дугаар А/41

Улаанбаатар хот

Аргачлал батлах тухай

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2, 20.3, 20.4, 20.5, 20.6, 20.7, 20.8, 20.10 дахь хэсэг, 32 дугаар зүйлийн 32.2.1 дэх хэсэг, Соёлын яамны 2021-2024 оны стратеги төлөвлөгөөний Стратегийн зорилт 2-ийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Соёлын өвийг бүртгэх "Соёлын өвийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн систем" ашиглахтай холбогдуулан "Бүртгэл, хөтлөх, ашиглах аргачлал"-ыг хавсралтаар баталсугай.

2.Энэхүү аргачлалыг соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэгч байгууллага, иргэнд түгээх, нэгдсэн арга зүйгээр хангаж ажиллахыг Бүртгэл, мэдээллийн газрын дарга (А.Саруул)-д даалгасугай.

3.Системийн хэвийн үйл ажиллагааг хангах, админ, орон нутгийн админд эрх олгох, тохируулах ажлыг зохион байгуулж ажиллахыг Мэдээллийн технологийн газрын дарга (Д.Сайнбаяр)-д үүрэг болгосугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (А.Ганбат)-д даалгасугай.

ЗАХИРАЛ



ГЭНХБАТ

172401017

Соёлын өвийн үндэсний төвийн захирлын
2024 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн
А/14 дугаар тушаалын хавсралт



СОЁЛЫН ӨВИЙН НЭГДСЭН БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМД БҮРТГЭЛ ХӨТЛӨХ, АШИГЛАХ АРГАЧЛАЛ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү аргачлал нь Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 20, 21, 22, 23, 24, 25, 26 дугаар зүйлийн дагуу соёлын өвийг бүртгэх, ашиглах, лавлагаа мэдээлэл, тайлан гаргах, сурталчлах үйл ажиллагааны чиглэл, зохион байгуулалтын дэс дарааллыг заасан баримт бичиг болно.

1.2. Соёлын өвийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн системд бүртгэл хөтлөх, ашиглах аргачлалыг "Соёлын өвийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн сангийн систем"-д /цаашид "систем" гэнэ/ соёлын биет болон биет бус өвийг бүртгэх, ашиглахад хэрэглэнэ.

1.3. Систем нь:

- мэдээллийн самбар;
- соёлын биет бус өвийн дэд систем;
- түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн дэд систем;
- түүх, соёлын үл хөдлөх дурсгалын дэд систем;
- баримтат өвийн дэд систем;
- админ удирдлага;
- медиа сангийн дэд систем;
- лавлагаа мэдээллийн дэд систем;
- орон зайн дэд систем;
- лог бүртгэлийн дэд систем гэсэн бүтэцтэй байна.

1.4. Систем нь тухайн шатны бүртгэл, мэдээллийн санг бүрдүүлэгч байгууллагын уялдаа холбоо, мэдээллийн урсгалыг хурдасгах, соёлын өвийг хадгалж хамгаалах чиглэлээр оновчтой бодлого, шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх, холбогдох байгууллагуудыг мэдээллээр түргэн шуурхай хангах, хянах, мэдээллийг хамтран ашиглах, сурталчлах зорилготой.

1.5. Систем нь <https://ncch.cis.mn/> домэйн нэртэй байна.

1.6. Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санг дараах иргэн, хуулийн этгээд системд нэвтрэх эрх авч хэрэглэгч үүсгэнэ. Үүнд:

1.6.1. байгууллагын бүртгэл, мэдээллийн сан;

1.6.2. сум, дүүргийн бүртгэл, мэдээллийн сан;

1.6.3. аймаг, нийслэлийн бүртгэл, мэдээллийн сан;

1.6.4. соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сан;

1.6.5.судалгааны байгууллага;

1.6.6.судлаач;

1.6.7.иргэн.

1.7.Системийг дараах этгээд ашиглах эрхтэй. Үүнд:

1.7.1.төрийн захиргааны төв байгууллага, төрийн болон орон нутгийн өмчийн захиргааны байгууллага;

1.7.2.тусгай чиг үүргийн байгууллага;

1.7.3.эрдэм шинжилгээний байгууллага;

1.7.4.аж ахуй нэгж, байгууллага;

1.7.5 иргэн.

1.8.Системд нэвтрэх, ашиглах хүсэлтэй байгууллага, иргэн Соёлын өвийн үндэсний төвд хүсэлт гаргана.

1.9.Соёлын өвийн үндэсний төв нь аргачлалын 1.7.1, 1.7.2, 1.7.3-д дурдсан байгууллагад системд нэвтрэх, ашиглах эрхийг төрийн цахим шуудангийн хаягийг үндэслэн олгоно.

Хоёр. Нэр томьёо

2.1.Энэхүү аргачлалд заасан нэр томьёог дараах утгаар ойлгоно:

2.1.1.“систем” гэдэг нь холбогдох техникийн орчин, сервер, тоног төхөөрөмж, үүлэн тооцоололд суурилсан программ хангамж зэргээс бүрдсэн ашиглагчийн удирдлагын болон хэрэглэгч хэрэглэх боломжтой төрөлжсөн дэд системийн цогц үйл ажиллагааг;

2.1.2.“Мэдээллийн самбар” гэдэг нь соёлын биет бус өв, түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл, түүх, соёлын үл хөдлөх дурсгал, баримтат өвийн дэд системд бүртгэгдсэн тоон үзүүлэлтүүдийг хэрэглэгчийн эрхийн түвшнээс хамаарч улс, аймаг, нийслэл, сум, дүүрэг, байгууллагын хэмжээнд харуулах модулийг;

2.1.3.“Соёлын биет бус өвийн дэд систем” гэдэг нь соёлын биет бус өв болон соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчтай холбоотой мэдээллийн модулийг;

2.1.4.“Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн дэд систем” гэдэг нь түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлтэй холбоотой мэдээллийн модулийг;

2.1.5.“Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын дэд систем” гэдэг нь түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газар, дурсгалтай холбоотой мэдээллийн модулийг;

- 2.1.6. "Баримтат өвийн дэд систем" гэдэг нь баримтат өвтэй холбоотой мэдээллийн модулийг;
- 2.1.7. "Админ удирдлага" гэдэг нь тухайн шатны бүртгэл, мэдээллийн нэгдсэн системийн цогц үйл ажиллагааг хангах, сайжруулах, шинэчлэх, хэрэглэгчийг үүсгэх, тохируулах зэрэг үйл ажиллагааны ерөнхий модулийг;
- 2.1.8. "Медиа сангийн дэд систем" гэдэг нь системд бүртгэгдсэн соёлын өвийн гэрэл зураг, дуу, дүрс бичлэг, гурван хэмжээст мэдээллийн сан үүсгэх хадгалах, ашиглах модулийг;
- 2.1.9. "Лавлагаа мэдээллийн дэд систем" гэдэг нь иргэн, хуулийн этгээдийн хүсэлтийг хүлээн авах, хуваарилах, шийдвэрлэх, тайлан мэдээ гаргах үйл ажиллагааны модулийг;
- 2.1.10 "Орон зайн дэд систем" гэдэг нь соёлын өвийн байршил, тархцын мэдээллийг газрын зураг ашиглах харуулах модулийг;
- 2.1.11. "Лог бүртгэлийн дэд систем" гэдэг нь системийг хэрэглэгч, ашиглагч нарын хийсэн бүхий л үйлдлийг түүх, үүсгэн хадгалах, харуулах модулийг;
- 2.1.12. "Супер админ" гэдэг нь системийн хэвийн үйл ажиллагааг хариуцах админ болон орон нутгийн админд эрх олгох, тохируулах үүрэгтэй Соёлын өвийн үндэсний төвийн холбогдох албан тушаалтныг;
- 2.1.13. "Админ" гэдэг нь төрийн болон орон нутгийн өмчийн захиргааны байгууллага, соёлын байгууллага, байгууллага, иргэнд систем ашиглах эрх олгох, тохируулах үүрэгтэй Соёлын өвийн үндэсний төвийн өв хариуцсан эрх бүхий албан тушаалтныг;
- 2.1.14. "Орон нутгийн админ" гэдэг нь тухайн засаг, захиргааны нэгжид хамаарах соёлын байгууллага, иргэн, хуулийн этгээдэд системд ашиглах эрх олгох, тохируулах эрх бүхий албан тушаалтныг;
- 2.1.15. "Хэрэглэгч" гэдэг нь админ, орон нутгийн админаас эрх авч системд соёлын өвийн бүртгэл, мэдээлэлтэй холбоотой үйл ажиллагааг гүйцэтгэх иргэн, эрх бүхий албан тушаалтныг;
- 2.1.16. "Ашиглагч" гэдэг нь админ, орон нутгийн админаас эрх авсан төрийн болон орон нутгийн өмчийн захиргааны байгууллага, тусгай чиг үүргийн байгууллага, эрдэм шинжилгээний байгууллага, судлаач зэрэг соёлын өвийн мэдээллийг хязгаартайгаар ашиглах иргэн, хуулийн этгээдийг;
- 2.1.17. "Баримтат өв" гэдэг нь түүхэн тодорхой орон зай, цаг үеийн аль нэг хэсгийг төлөөлж чадах байгаль, нийгэм, түүх, соёл, урлаг, шинжлэх ухааны үнэ цэн, ач холбогдол бүхий мэдээлэл агуулсан төрөл бүрийн эд материал дээр бичсэн ном бичгийн зүйл, дуу, дүрсээр баримтжуулан үлдээсэн дурсгалыг;

2.1.18. "Улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сангийн дугаар" гэдэг нь соёлын өвийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн системд бүртгэгдсэнийг баталгаажуулсан дугаарыг;

2.1.19. "GLAM" гэдэг нь системд бүртгэгдсэн өвийг олон нийтэд дамжуулан сурталчлах системийг.

Гурав. Соёлын өвийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн системийн бүтэц

3.1. "Соёлын өвийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн сангийн систем"-ийн Мэдээллийн самбар нь:

- нэгдсэн самбар,
- соёлын биет бус өв,
- соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч,
- түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл,
- түүх, соёлын үл хөдлөх дурсгал,
- Баримтат өвийн төрлөөр холбогдох тоон үзүүлэлтийг харуулна.

3.2. Соёлын биет бус өвийн дэд систем нь:

- соёлын биет бус өвийн бүртгэл,
- соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн бүртгэл,
- соёлын биет бус өвийн тайлан гэсэн дэд хэсгээс бүрдэнэ.

3.3. Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн дэд систем нь:

- түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэл,
- үзэсгэлэнгийн бүртгэл,
- түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тайлан гэсэн дэд хэсгээс бүрдэнэ.

3.4. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын дэд систем нь:

- түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газрын бүртгэл,
- түүх, соёлын үл хөдлөх дурсгалтын бүртгэл,
- түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тайлан гэсэн дэд хэсгээс бүрдэнэ.

3.5. Баримтат өвийн дэд систем нь:

- баримтат өвийн бүртгэл,
- баримтат өвийн тайлан,
- баримтат өвийн файл гэсэн дэд хэсгээс бүрдэнэ.

3.6. Админ удирдлагын дэд систем нь:

- өмчлөгч,
- эзэмшигч,
- хэрэглэгчийн жагсаалт,
- өвийн төрөл,
- соёлын биет бус өв,
- түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл,
- түүх, соёлын үл хөдлөх дурсгал,
- баримтат өв гэсэн дэд хэсгээс бүрдэнэ.

3.7. Медиа сангийн дэд систем нь:

- соёлын биет бус өв медиа сан,
- соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн медиа сан,
- түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн медиа сан,
- түүх, соёлын үл хөдлөх дурсгалын медиа сан,
- баримтат өвийн медиа сан гэсэн дэд хэсгээс бүрдэнэ.

3.8. Лавлагаа мэдээллийн дэд систем нь:

- лавлагааны жагсаалт,
- тайлан гэсэн дэд хэсгээс бүрдэнэ.

3.9. Орон зайн дэд систем нь:

- соёлын биет бус өвийн тархац,
- соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн тархац,
- түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газрын тархац гэсэн дэд хэсгээс бүрдэнэ.

3.10. Лог бүртгэлийн дэд систем нь:

- хэрэглэгчийн лог,
- бүртгэл өөрчлөлтийн түүх гэсэн дэд хэсгээс бүрдэнэ.

Дөрөв. Системд хандах эрх

4.1. Систем нь дараах хандах эрхтэй байна. Үүнд:

4.1.1. "Супер админ" нь орон нутгийн болон байгууллагын админд хандах эрх олгох, тохируулах, цуцлах эрхтэй бөгөөд системийн хэвийн үйл ажиллагааг хариуцах, алдаа гэмтэл гарсан тохиолдолд мэдэгдэх, системд хөгжүүлэлт, сайжруулалт хийхтэй холбоотой асуудлыг хариуцах, тухайн шатны админд сургалт, зааварчилгаа өгнө.

4.1.2. "Админ" нь төрийн болон орон нутгийн өмчийн захиргааны байгууллага, аймаг, нийслэлийн соёл, урлагийн газар, музей, байгууллагаас эрх олгосон албан тушаалтан болон иргэнд системд ажиллах эрх олгох, тохируулах, цуцлах эрх өгнө.

4.1.3. "Орон нутгийн админ" нь тухайн шатны засаг захиргаа, түүний нэгжийн хамаатах музей, орон нутаг судлах танхим, байгууллаас эрх олгосон албан тушаалтанд системд ажиллах эрх олгох, тохируулах, цуцлах эрх өгнө.

4.1.4. "Ашиглагч нь" системд бүртгэгдсэн соёлын өвийн холбогдох мэдээллийг "Статистик тоон дүн мэдээ харах" эрхийг ашиглан харна.

4.1.5. "Ашиглагч нь" хандах эрх авах хүсэлтээ тухайн шатны эрх олгогдсон байгууллагад албан хүсэлтээр уламжлан авна.

Тав. Соёлын өвийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн системийн үйлдэл

5.1. Соёлын өвийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн систем нь:

- нэмж бүртгэх,
- засах,
- хайлт, шүүлт хийх,
- хадгалах
- сонгох
- татах,
- цэвэрлэх
- баталгаажуулах,
- жагсаалт үйлдэх,
- харах
- устгах
- хэвлэх үйлдлийг хийнэ.

Зургаа. Соёлын биет бус өвийн дэд системд бүртгэл хөтлөх

6.1. Соёлын биет бус өвийн бүртгэл

6.1.1. **УНБ Сангийн дугаар:** Энэ дугаарыг зөвхөн бүртгэл хийж баталгаажуулсны дараа систем автоматаар өгнө. (ББ- Биет бус өв, үсгийн араас 7 оронтой тоог автоматаар өгнө. Бүртгэгдсэн дэс дарааллын дагуу дугаарлагдана).

6.1.2. **Соёлын биет бус өвийн нэр:** Тухайн Соёлын биет бус өвийн илэрхийллийн нэрийг бичнэ.

6.1.3. **Соёлын биет бус өвийн бүртгэл:** Тухайн Соёлын биет бус өвийн Монгол Улсын соёлын биет бус өвийн Төлөөллийн үндэсний бүртгэл, Монгол Улсын Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн үндэсний бүртгэл, Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд шинээр бүртгэх өв гэсэн 3 сонголтын алинд хамаарахыг сонгоно.

Монгол Улсын соёлын биет бус өвийн Төлөөллийн үндэсний бүртгэл, Монгол Улсын Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн үндэсний бүртгэлийг сонгосон тохиолдолд соёлын биет бус өвийн бүртгэлийн дэд системийн 1.2.2. дэх хэсэгт Өвийн нэрийг бичнэ.

Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд шинээр бүртгэх өв сонголтыг сонгосон тохиолдолд системийн 1.2.2. дэх хэсэгт өвийн нэр гарч ирэхгүй бөгөөд гараас бичиж оруулна. Мөн холбогдох ай савыг сонгоно.

6.1.4. **Ай сав:** Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны 11 дүгээр сарын 29-ны өдрийн А/759 дугаар тушаалын 1-р хавсралтаар батлагдсан Монгол Улсын биет бус соёлын өвийн төлөөллийн үндэсний бүртгэлийн 7 ай савын ангиллаас сонгоно.

6.1.5. **Соёлын биет бус өвийн тушаал, шийдвэр:** Тухайн Соёлын биет бус өвийг Төлөөллийн болон Яаралтай хамгаалах шаардлагатай өвд бүртгэгдсэнийг нотлох тушаал, шийдвэрийг хавсаргана.

6.1.6.ЮНЕСКО-д бүртгэгдсэн эсэх: Монгол Улсаас ЮНЕСКО-ийн Хүн төрөлхтний соёлын биет бус өвийн төлөөллийн жагсаалт, Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн жагсаалтад бүртгэгдсэн өв, Бүртгэлгүй гэсэн 3 сонголтоос аль хамаарах хэсгийг сонгоно. ЮНЕСКО-ийн Хүн төрөлхтний соёлын биет бус өвийн төлөөллийн жагсаалт, Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн жагсаалтад бүртгэгдсэн өв гэсэн сонголтыг сонгосон тохиолдолд бүртгэгдсэн өвийн сонголтууд гарч ирэх бөгөөд аль тохирохыг сонгоно. Бүртгэлгүй гэсэн сонголтыг сонговол нэмэлт жагсаалт гарч ирэхгүй.

6.1.7.Нэмэх: 6.1.6-д хамаарал бүхий баримт материалыг PDF хэлбэрээр оруулна.

6.1.8.Соёлын биет бус өвийн тухай мэдээлэл: Тухайн бүртгэгдэж буй өвд холбогдох дэлгэрэнгүй мэдээллийг бичнэ:

6.1.8.1.өвийн тархац: Тухайн соёлын биет бус өвийн тархсан байдлын талаар бичнэ (Бусад аймаг, сум, угсаатанд байдаг эсэх гэх мэт),

6.1.8.2.өвийн тархац байршлаар: Тухайн соёлын биет бус өвийн илэрсэн газар, нутаг буюу бүртгэж хийж буй мэргэжилтэн өөрийн хот/аймаг, дүүрэг/сум, хороо/багийн газрын байршлыг бичнэ,

6.1.8.3.соёлын өвийн хамрах хүрээний солбицол: Тухайн соёлын биет бус өвийн илэрсэн газар, нутаг буюу бүртгэж хийж буй мэргэжилтэн өөрийн хот/аймаг, дүүрэг/сум, хороо/багийн хамрах хүрээний солбицлыг бичнэ,

6.1.8.4.өвийн онцлог шинж чанар, холбогдох зан үйл: Соёлын биет бус өвийн бусдаас ялгарах онцлог шинж болон одоогийн байдал, холбогдох зан үйлийн талаар бичнэ,

6.1.8.5.өвийн дэг сургууль, арга барил: Соёлын биет бус өвийг суралцсан арга барил, дэг сургуулийн онцлогийг бичнэ,

6.1.8.6.өвтэй холбогдох хорио цээр: Тухайн соёлын биет бус өвд холбогдох хорио цээрийн талаар дэлгэрэнгүй бичнэ,

6.1.8.7.өвийн гэрэл зураг: Гэрэл зургийг оруулахдаа тухайн талбар дахь мэдээллийг бүрэн бөглөнө. Соёлын биет бус өв болон өвийг үйлдэж буй гэрэл зураг (3 дээш байх), оруулах зургийн хэмжээ нь 10MB илүүгүй, JPG, PNG өргөтгөлтэй байна,

6.1.8.8.өвтэй холбоотой дүрс бичлэг: Соёлын биет бус өвийг илэрхийлж буй дэг сургуулийн онцлог, гүйцэтгэх арга барилыг илтгэсэн дүрс бичлэг байна. Оруулах бичлэгийн хэмжээ нь 100MB илүүгүй, mp4 өргөтгөлтэй байна,

6.1.8.9.өвтэй холбоотой дуу бичлэг: Тухайн соёлын биет бус өвийг илэрхийлэх дуу бичлэг оруулна. Оруулах дуу бичлэгийн хэмжээ нь 50MB илүүгүй, mp4 өргөтгөлтэй байна,

6.1.8.10.соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санд хадгалагдаж байгаа өвтэй холбоотой материал: Тус соёлын биет бус өвд холбогдох мэдээлэл агуулсан архивын материалыг холбогдох хүснэгтийн дагуу тэмдэглэнэ,

6.1.8.11.өв бүртгэхтэй холбоотой хэрэглэгдэхүүн: Тухайн Соёлын биет бус өвд холбогдох хээрийн болон төрөл бүрийн судалгааны хэрэглэгдэхүүнийг хүснэгтийн дагуу тэмдэглэж PDF файлыг хавсаргана,

6.1.8.12.өвтэй холбоотой судалгааны хэрэглэгдэхүүн: Тухайн Соёлын биет бус өвтэй холбоотой хэвлэгдсэн сэтгүүл, ном зүйн судалгааны хэрэглэгдэхүүнийг хүснэгтийн дагуу тэмдэглэж PDF файлыг хавсаргана,

6.1.8.13.тухайн өвийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Төрийн байгууллага, ТББ, хамт олон, бүлэг хүмүүс, иргэн байдаг эсэх: Тухайн Соёлын биет бус өвийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буйг тодруулж бичнэ.

6.2.Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн бүртгэл нь цахим системд Бүртгэл 1, Бүртгэл 2 гэсэн хэсгээс бүрдэнэ. Бүртгэл 1-д өвлөн уламжлагч хүний хувийн мэдээлэл, Бүртгэл 2-д тухайн өвлөн эзэмшсэн өвийн тухай мэдээлэл хамаарна.

6.2.1.УНБСангийн дугаар: Энэ дугаарыг зөвхөн бүртгэл хийж баталгаажуулсны дараа систем автоматаар өгнө. Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн бүртгэлийг асуулгын дагуу бөглөж хадгалах ба улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд мэдээллийг хүлээн авч баталгаажуулсны дараа олгогдоно.

6.2.2. Өвлөн уламжлагчийн тухай мэдээлэл: Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн гэрэл зургийг upload хийнэ оруулна. Оруулах зургийн хэмжээ нь 1.5 MB илүүгүй, JPG, PNG өргөтгөлтэй байна.

6.2.3.Регистрийн дугаар: Энэ хэсэгт өвлөн уламжлагчийн регистрийн дугаарыг оруулна.

6.2.4.Ургийн овог: Өвлөн уламжлагчийн ургийн овгийг үнэн зөв бичнэ.

6.2.5.Эцэг(эх)-ийн нэр: Өвлөн уламжлагчийн эцэг, эхийн нэрийг бичнэ.

6.2.6.Өөрийн нэр: Өвлөн уламжлагчийн өөрийн нэрийг бичнэ.

6.2.7.Хүйс: Эрэгтэй, эмэгтэй сонголтоос тохирохыг сонгоно.

6.2.8.Яс үндэс: Угсаатны зүйн бүлгээс аль тохирохыг сонгоно.

6.2.9.Төрсөн он, сар, өдөр: Өвлөн уламжлагчийн төрсөн он, сар, өдрийг календариас сонгоно.

6.2.10.Үндсэн захиргаа: Тухайн өвлөн уламжлагчийн төрсөн газар буюу уугуул аймаг, сумын нэрийн бичнэ.

6.2.11.Оршин суугаа хаяг: Өвлөн уламжлагчийн байнга оршин суух хаягийг аймаг, сум, нийслэл, дүүргийн нэр, баг, хорооны нэр, дугаар, хороолол, гудамжны нэр, байр, хаалганы дугаар, газар зүйн нэр /газар, усны/-ийг оруулна (Иргэний Улсын бүртгэлийн тухай хуулийн 8.1. дэх хэсэгт Иргэн иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгэлтэй хаягаас өөр хаягт шилжин 180 хоногоос дээш хугацаагаар оршин суухаар бүртгүүлэхийг байнга, 180 хоног ба түүнээс доош хугацаагаар оршин суухаар бүртгүүлэхийг түр оршин суух гэнэ).

Мөн Хур систем нь өвлөн уламжлагчийн оршин суугаа хаягийн мэдээллийг оны төгсгөлд автоматаар шинэчлэгдэнэ.

6.2.12.Боловсрол: Өвлөн уламжлагчийн боловсролын талаарх мэдээллийг боловсролгүй болон сургуулийн өмнөх, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн, дээд боловсролыг эзэмшсэн эсэхийн аль тохирохыг сонгоно.

6.2.13.Мэргэжил: Өвлөн уламжлагчийн мэргэжил болон чадамжийн түвшнийг гэрчилсэн албан ёсны баталгааг үндэслэн эзэмшсэн мэргэжлийг бичиж оруулна.

6.2.14.Хөдөлмөр эрхлэлт: Тухайн өвлөн уламжлагчийн ажил хөдөлмөр эрхэлж буй байдлыг төрийн байгууллага, хувийн хэвшил, хувиараа хөдөлмөр эрхлэгч, малчин, тэтгэвэрт, оюутан гэсэн аль тохирохыг сонгоно.

6.2.15.Алдар цол, гавьяа шагнал: Тухайн өвлөн уламжлагч нь Хөдөлмөрийн хүндэт, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон, Алтан гадас, Соёлын гавьяат зүтгэлтэн, Урлагийн гавьяат зүтгэлтэн, Хөдөлмөрийн баатар, Бусад гэсэн сонголтоос 1 ба түүнээс олон утгыг бөглөж болно.

6.2.16.Холбоо барих утас: Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн өөрийнх нь холбоо барих утасны дугаарыг бичнэ.

6.2.17.Гэр бүл, ойрын хүний утас: Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн гэр бүлийн нэг гишүүний утасны дугаарыг бичнэ.

6.2.18.Хөгжлийн бэрхшээлтэй эсэх: Тухайн өвлөн уламжлагч хэрэв хөгжлийн бэрхшээлтэй бол "Тийм" сонголтоор Харааны, Ярианы, Сонсголын, Хөдөлгөөний, Оюун ухааны хомсдолтой, Сэтгэцийн, Хавсарсан, Бусад гэсэн сонголтоос 1 ба түүнээс олон утгыг бөглөж болно.

6.2.19.Амьд сэрүүн байгаа эсэх: Хэрэв тухайн өвлөн уламжлагч амьд сэрүүн байгаа бол "Тийм", нас барсан тохиолдолд "Үгүй" сонголтыг сонгож нас барсан он, сар, өдрийг бичнэ.

6.2.20.Өвийн бүртгэл: Тухайн Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн голлон эзэмшсэн өв нь Монгол Улсын соёлын биет бус өвийн төлөөллийн үндэсний бүртгэл, Монгол Улсын Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн үндэсний бүртгэл, Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд шинээр бүртгэх өв (7 ай сав 363 өвийн жагсаалтад бүртгэгдээгүй шинээр илрүүлсэн өвийг)-ийн бүртгэлийн алинд хамаарахыг сонгоно.

6.2.21.Голлож эзэмшсэн өвийн нэр: Зааврын 6.2.20. Монгол Улсын соёлын биет бус өвийн Төлөөллийн үндэсний бүртгэл, Монгол Улсын Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн үндэсний бүртгэлийг сонгосон тохиолдолд тохирох ай савыг сонгон өвийн нэрийг бичих бол харин Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд шинээр бүртгэх өвийг сонгосон бол зөвхөн ай савын нэрийг сонгоно.

6.2.22.Ур чадварын түвшин: Тухайн өвлөн уламжлагчийн голлож эзэмшсэн өвийн ур чадварын түвшнийг “маш сайн”, “сайн”, “дунд”, “муу” гэсэн сонголтоос тухайн хүн өөрийгөө үнэлэн сонгох ба өвлөн уламжлагчийн саналыг үндэслэн бүртгэнэ.

6.2.23.Хэд дэх үеийн өвлөн уламжлагч бэ?: Тухайн өвлөн уламжлагч хэд дэх үеийн өвлөн уламжлагч болохыг “1 дэх үе”, “2 дахь үе”, “3 дахь үе”, “4 дэх үе”, “5 ба түүнээс дээш” гэсэн сонголтоос сонгоно.

6.2.24. Өвлөн уламжилсан өвийн мэдээлэл: Тухайн өвлөн уламжлагчийн голлох өвийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг бичнэ.

6.2.25.Өвийн дэг сургууль, арга барил: Соёлын биет бус өвийг сурах арга барил, дэг сургуулийн онцлогийг бичнэ.

6.2.26.Өвийн онцлог шинж чанар, холбогдох зан үйл: Өвийн бусдаас ялгарах онцлог шинж, зан үйл болон одоогийн нөхцөл байдлын талаар бичнэ.

6.2.27.Өвтэй холбогдох хорио цээр: Соёлын биет бус өвийг гүйцэтгэхтэй холбоотой хорио цээрийн зан үйлийг бичнэ.

6.2.28.Өвийн гэрэл зураг: Тухайн соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн голлох өвийг илэрхийлэх гэрэл зургийг оруулахдаа тухайн талбар дахь мэдээллийг бүрэн бөглөнө. Соёлын биет бус өв болон өвийг үйлдэж буй гэрэл зураг (3 дээш байх), оруулах зургийн хэмжээ нь 10MB илүүгүй, JPG, PNG өргөтгөлтэй байна.

6.2.29.Өвтэй холбоотой дүрс бичлэг: Тухайн соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн голлох өвийг үйлдэж буй дэг сургуулийн онцлог, гүйцэтгэх арга барилыг илтгэсэн дүрс бичлэг байна. Оруулах бичлэгийн хэмжээ нь 100MB илүүгүй, mp4 өргөтгөлтэй байна.

6.2.30.Өвтэй холбоотой дуу бичлэг: Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн голлох өвийг гүйцэтгэж буй дуу бичлэгийг оруулна. Оруулах дуу бичлэгийн хэмжээ нь 50MB илүүгүй, mp4 өргөтгөлтэй байна.

6.2.31.Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санд хадгалагдаж байгаа өвтэй холбоотой материал: Бүртгэл,мэдээллийн санд хадгалагдаж байгаа тухайн өвлөн уламжлагчтай холбогдолтой гэрэл зураг, негатив хальс, дуу дүрс бичлэгийг хуурцаг, CD/ DVD/ архив, ном, хэвлэлийн бичиг баримт, бусад баримтын “тоо ширхэг”, “хадгаламжийн дугаар” бичигдэнэ. Тухайн бүртгэл, мэдээллийн сан дээрх баримтаа хадгаламжийн нэгж үүсгэсэн хадгалах ба уг хадгаламжийн хаана тухайн дурсгалын тухай материал ямар дугаартай, хэдэн ширхэг байгааг “тоо ширхэг”, “хадгаламжийн дугаар” хэсэгт бичнэ.

6.2.32.Өвлөн уламжлагч хүнтэй холбоотой судалгааны хэрэглэгдэхүүн: Тухайн Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч хүнтэй холбогдох судалгааны хэрэглэгдэхүүнийг PDF файлаар оруулж тайлбар хэсэгт товч агуулгыг бичнэ.

6.2.33.Өвлөн уламжилсан байдал: Тухайн соёлын биет бус өвийг өвлөн уламжилсан байдлыг “Үе дамжсан”, “Академик”, “Бие дааж сурсан”, “Шавь сургалтаар”, “Төрөл садан, хамаатан” гэсэн сонголтуудаас аль тохирохыг сонгоно.

6.2.34.Өвлөн уламжилсан арга зам: Тухайн соёлын биет бус өвийг хэнээс, ямар арга замаар өвлөн уламжилсан талаарх дэлгэрэнгүй мэдээллийг бичнэ.

6.2.35.Соёлын биет бус өвийг ур чадварын өндөр түвшинд өвлөн уламжилсан өвлөн уламжлагчийн үндэсний жагсаалтад бүртгэгдсэн эсэх: Тухайн соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч нь Засгийн газрын 2019 оны 475 дугаар тогтоолын хавсралтаар баталсан 102 өвлөн уламжлагчийн жагсаалтаар бүртгэгдсэн бол “Тийм” үгүй бол “Үгүй” гэсэн сонголтыг сонгоно.

6.2.36.Өвлөн уламжлагчийн дагалдах өвийн мэдээлэл: Дагалдах өвийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг “нэмэх” хэсгийг сонгон хүснэгтийн дагуу нөхөж бичнэ. (Жич: Дагалдах өвийн тоо харгалзахгүй.) Дагалдах өв гэдэг нь тухайн өвлөн уламжлагчийн хамгийн сайн эзэмшсэн өв болох голлох өвөөс гадна өвийн төрлийн хувьд голлох өвтэй ижил төстэй бус харин Соёлын биет бус өвийн өөр төрөлд хамаарах нэг (нэг ба хэд ч байж болох) өвийг эзэмшсэн бол түүнийг хэлнэ:

6.2.36.1 дагалдах өвийн бүртгэл: Тухайн Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн голлон эзэмшсэн өв нь Монгол Улсын соёлын биет бус өвийн Төлөөллийн үндэсний бүртгэл, Монгол Улсын Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн үндэсний бүртгэл, Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд шинээр бүртгэх өвийн алинд хамаарахыг сонгоно,

6.2.36.2. **дагалдах өвийн нэр:** Зааврын 6.2.36.1. Монгол Улсын соёлын биет бус өвийн Төлөөллийн үндэсний бүртгэл, Монгол Улсын Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн үндэсний бүртгэлийг сонгосон тохиолдолд тохирох ай сав, өвийн нэрийг сонгоно, тухайн өвийг улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд шинээр бүртгэх бол ай савыг сонгон нэрийг бичнэ,

6.2.36.3. **дагалдах өвийн ур чадварын түвшин:** Тухайн өвлөн уламжлагчийн дагалдах өвийн ур чадварын түвшнийг “маш сайн”, “сайн”, “дунд”, “муу” гэсэн сонголтоос тухайн хүн өөрийгөө үнэлэн сонгох ба өвлөн уламжлагчийн саналыг үндэслэн бүртгэнэ,

6.2.36.4. **хэд дэх үеийн өвлөн уламжлагч вэ?:** Тухайн өвлөн уламжлагч хэд дэх үеийн өвлөн уламжлагч болохыг “1 дэх үе”, “2 дахь үе”, “3 дахь үе”, “4 дэх үе”, “5 ба түүнээс дээш” гэсэн сонголтоос сонгоно,

6.2.36.5. **дагалдах өвийг өвлөн уламжилсан байдал:** Тухайн соёлын биет бус өвийг өвлөн уламжилсан байдлыг “Үе дамжсан”, “Академик”, “Бие дааж сурсан”, “Шавь сургалтаар”, “Төрөл садан, хамаатан” гэсэн сонголтуудаас аль тохирохыг сонгоно,

6.2.36.6. **өвлөн уламжилсан арга зам:** Тухайн соёлын биет бус өвийг хэнээс ямар арга замаар өвлөн уламжилсан талаарх дэлгэрэнгүй мэдээллийг бичнэ,

6.2.36.7. **дагалдах өвийн тухай дэлгэрэнгүй мэдээлэл:** Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн дагалдах өвтэй холбоотой зан үйл, хорио цээр, онцлог шинжийн талаар дэлгэрүүлж бичнэ.

6.3. Соёлын биет бус өвийн тайлан

6.3.1. Соёлын биет бус өвийн тоон дүн

Энэ хэсэгт системд бүртгэгдсэн соёлын биет бус өвийн тоон дүнг дурын болон тайлант хугацаагаар боловсруулж, дүн мэдээг дараах 3 үзүүлэлтээр гаргана.

6.3.1.1. Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд шинээр бүртгэгдсэн өвийн тоон дүн,

6.3.1.1.1. Монгол Улсын соёлын биет бус өвийн Төлөөллийн үндэсний бүртгэлд бүртгэгдсэн өвийн тоон дүн,

6.3.1.1.2. Монгол Улсын Яаралтай хамгаалах шаардлагатай үндэсний бүртгэлд бүртгэгдсэн өвийн тоон дүн.

6.3.2 ЮНЕСКО-д бүртгэгдсэн Соёлын биет бус өвийн тоон дүн

Системд бүртгэгдсэн соёлын биет бус өвийн тоон дүнгээс ЮНЕСКО-д бүртгэгдсэн өвийн мэдээг дараах 2 үзүүлэлтээр гаргана.

6.3.2.1. ЮНЕСКО-ийн Хүн төрөлхтний СББӨ-ийн төлөөллийн жагсаалтад бүртгэгдсэн өвийн дүн,

6.3.2.2. ЮНЕСКО-ийн Яаралтай хамгаалах шаардлагатай СББӨ-ийн жагсаалтад бүртгэгдсэн өвийн дүн.

6.3.3. Соёлын биет бус өвийн тоон дүн/ай сав/

Системд бүртгэгдсэн өвийн тоон дүнг засаг, захиргааны нэгж болон 7 ай савын хүрээнд гаргана.

6.3.4. Соёлын биет бус өвийн өвлөн уламжлагчийн тоон дүн

Системд бүртгэгдсэн нийт өвлөн уламжлагч хүний тоон дүнг 7 ай сав, 3 үзүүлэлтээр гаргана.

6.3.4.1. Монгол Улсын соёлын биет бус өвийн Төлөөллийн үндэсний бүртгэлд бүртгэгдсэн өвийн тоон дүн (хүйсээр),

6.3.4.2. Монгол Улсын Яаралтай хамгаалах шаардлагатай үндэсний бүртгэлд бүртгэгдсэн өвийн тоон дүн (хүйсээр),

6.3.4.3. Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд бүртгэгдсэн соёлын биет бус өвийн дүн (хүйсээр).

6.3.5. Соёлын биет бус өвийн ур чадварын өндөр түвшинд өвлөн эзэмшсэн “Соёлын биет бус өвийн үндэсний жагсаалт” (ай сав, хүйсээр)

Засгийн газрын тогтоолоор Соёлын биет бус өвийн ур чадварын өндөр түвшинд өвлөн эзэмшсэн “Соёлын биет бус өвийн үндэсний жагсаалт”-д бүртгэгдсэн өвлөн уламжлагч хүний тоог засаг, захиргааны нэгж, 7 ай сав болон хүйсээр гаргана.

6.3.6. Боловсролын түвшний дэлгэрэнгүй дүн (тоо, аймаг, нийслэл, сум, дүүрэг)

Системд бүртгэгдсэн өвлөн уламжлагчийн боловсролын түвшнийг засаг, захиргааны нэгж, хүйсээр гаргана.

6.3.7. Боловсролын түвшний дэлгэрэнгүй дүн (тоо, ай сав)

Системд бүртгэгдсэн өвлөн уламжлагчийн боловсролын түвшнийг 7 ай сав, хүйсээр гаргана.

6.3.8. Насны бүлгийн мэдээлэл (тоо, аймаг, нийслэл, сум, дүүрэг)

Системд бүртгэгдсэн өвлөн уламжлагчийн насны бүлгийн мэдээллийг засаг, захиргааны нэгж, хүйсээр гаргана.

6.3.9. Насны бүлгийн мэдээлэл(тоо, ай сав)

Системд бүртгэгдсэн өвлөн уламжлагчийн насны бүлгийн мэдээллийг 7 ай сав, хүйсээр гаргана.

6.3.10. Хөдөлмөр эрхлэлтийн мэдээлэл(тоо, ай сав)

Системд бүртгэгдсэн өвлөн уламжлагчийн хөдөлмөр эрхлэлтийн мэдээллийг засаг, захиргааны нэгж, хүйсээр гаргана.

6.3.11.Хөдөлмөр эрхлэлтийн мэдээлэл(тоо, аймаг, нийслэл, сум, дүүрэг)

Системд бүртгэгдсэн өвлөн уламжлагчийн хөдөлмөр эрхлэлтийн мэдээллийг 7 ай сав, хүйсээр гаргана.

6.3.12. Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн шилжилт хөдөлгөөний дүн

Системд бүртгэгдсэн өвлөн уламжлагчийн шилжилт хөдөлгөөний тоон дүнг ирсэн, явсан болон хүйсээр гаргана.

6.3.13.Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн шилжилт хөдөлгөөний дэлгэрэнгүй дүн (тоо, аймаг, нийслэл, сум, дүүрэг)

Системд бүртгэгдсэн өвлөн уламжлагчийн шилжилт хөдөлгөөний тоон дүнг холбогдох мэдээлэл болон шилжиж явсан, ирсэн хөдөлгөөнийг шилжсэн огноогоор гаргана.

Долоо. Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн
дэд системд бүртгэл хөтлөх

7.1.Түүх соёлын хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэл нь өмчлөгч, эзэмшигчийн мэдээлэл, үндсэн мэдээлэл, дэлгэрэнгүй мэдээлэл, нэмэлт мэдээлэл, медиа сан, улсын тооллогын мэдээлэл гэсэн хэсгээс бүрдэнэ.

7.1.1.Өмчийн хэлбэр: Тухайн түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг өмчилж буй байгууллага, иргэний өмчлөлийн хэлбэрээс хамаарч төрийн, орон нутгийн, шашны, олон нийтийн, хувийн хэвшлийн, иргэний гэсэн сонголтоос аль тохирохыг сонгоно.

7.1.2 Өмчлөгч: Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн өмчлөлийн хэлбэрээс төрийн, орон нутгийн, шашны, олон нийтийн гэсэн сонголтыг сонгосон тохиолдолд өмчлөгч нь “Монгол Улс” гэж автоматаар сонгогдоно. Харин хувийн хэвшлийн, иргэний гэсэн сонголтыг сонгосон бол иргэн, хуулийн этгээдийн нэрийг сонгоно.

7.1.3.Эзэмшигч: Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг эзэмшигч байгууллага, иргэний алба ёсны овог нэрийг сонгоно.

7.1.4.Музейн зэрэглэл: Төрийн болон орон нутгийн өмчийн музей, байгууллага нь тохирох зэрэглэлийг сонгоно.

7.1.5.УНБСангийн дугаар: Энэ дугаарыг зөвхөн бүртгэл хийж баталгаажуулсны дараа систем автоматаар өгнө. Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн УНБСангийн дугаар нь ХД0000000 байна (ХД- хөдлөх дурсгал 7 орон тоо нь улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд бүртгэгдсэнийг тус тус заана).

7.1.6. **Дурсгалт зүйлийн нэр:** Тухайн түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн нэрийг бичнэ.

7.1.7. **Хувийн дугаар:** Музейн үзмэр, эд өлгийн зүйлийн ерөнхий бүртгэлд бичигдсэн үзмэр, эд өлгийн зүйлийн хувийн дугаарыг бичнэ.

7.1.8. **Сан хөмрөгийн төрөл:** Музейн үзмэр, эд өлгийн зүйлийн ерөнхий бүртгэлд үндсэн, туслах сан хөмрөгт бүртгэгдсэн эсэхээс хамаарч аль тохирохыг сонгоно.

7.1.9. **Төрөл зүйл:** Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн программуудад ашиглагдаж буй "Төрөл зүйл"-ийг Археологийн, түүхийн, угсаатны зүйн, шашин шүтлэг, урлаг уран сайхан, байгалийн өв гэсэн ерөнхий 6 ангиллаар төрөлжүүлэн бүртгэдэг. 6 ангилал нь нийт 50 дэд ангилалд хуваагдаж, 50 дэд ангилал нь 845 нэршилд хуваагддаг бөгөөд тус ангилал бүрийн сонголтуудаас аль тохирохыг сонгоно.

7.1.10. **Холбогдох он цаг:** Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг бүтээсэн болон холбогдох он цагийг түүхэн он цагийн үечлэлд хамруулан сонгоно.

7.1.11. **Дурсгалыг бүтээсэн он:** Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн бүтээсэн он, цаг тодорхой бол энэ хэсэгт бичнэ.

7.1.12. **Соёлын өвийн зэрэглэл:** Тухайн түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл нь холбогдох журмын дагуу хосгүй үнэт, үнэт зэрэглэлд батлагдсан бол зэрэглэлийн нэрийг, үгүй бол зэрэглэлд хамрагдаагүй сонголтыг сонгоно.

7.1.13. **Зэрэглэлийн шийдвэр:** Тухайн түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл нь Засгийн газрын тогтоолоор хосгүй үнэт зэрэглэлд, Соёлын сайдын тушаалаар үнэт зэрэглэлд батлагдсан бол тушаал шийдвэрийн нэрийг сонгоно.

7.1.14. **Тоо ширхэг:** Тухайн түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тоо, ширхгийг бичнэ.

7.1.15. **Иж бүрдлийн бүрэлдэхүүн хэсгийн тоо ширхэг:** Тухайн түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл олон хэсгээс бүрдэж байгаа бол иж бүрдэл бүрийн нийт тоо, ширхгийг бичнэ.

7.1.16. **Эх бүтээл:** Тухайн дурсгал эх бүтээл болон хуулбар болохыг ялган "Тийм", "Үгүй" гэсэн сонголтыг хийнэ.

7.1.17. **Ховор, түгээмэл байдал:** Тухайн түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн ховор, түгээмэл байдлыг харгалзан "Нэн ховор", "Ховор", "Түгээмэл" сонголтоос тохирохыг сонгоно.

7.1.18. **Ашиглалтын байдал:** Тухайн түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл нь үзүүлэлт дэглээтэй байгаа эсвэл сан хөмрөгт хадгалагдаж байгаагаас хамаарч "үзүүлэлт", "Сан хөмрөг" гэсэн сонголтоос тохирохыг сонгоно.

7.1.19. **Үнэлгээ:** Төрийн болон орон нутгийн өмчийн музей, байгууллага нь санхүүгийн тайлангийн Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн дансанд бүртгэгдсэн үнийг бичнэ. Харин шашны, олон нийтийн, хувийн хэвшлийн, иргэний түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн үнэлгээг тухайн байгууллагын санхүүгийн тайланд тусгагдсан үнийг бичнэ.

7.1.20. **Олон нийтэд харуулах эсэх:** Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн холбогдох мэдээллийг иргэн, судлаачдад хүргэх талбар. Энэхүү талбарыг GLAM системд харуулах бол "тийм" "үгүй" гэсэн сонголтыг сонгоно. Тийм сонголтыг сонгосон тохиолдолд олон нийтэд зориулсан талбар гарч ирнэ:

7.1.20.1. **олон нийтэд зориулсан тайлбар:** Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн талаар олон нийтэд зориулсан товч тайлбарыг бичнэ.

7.1.21. **Олон улс, орон нутаг, шинжлэх ухааны нэр:** Олон нийтэд нийтлэг тархсан, орон нутагт угсаатны бүлгийн нэрлэж заншсан нэр болон олон улсад, шинжлэх ухааны эргэлтэд түгээмэл хэрэглэгддэг нэрийг бичнэ.

7.1.22. **Гарал үүсэл:** Тухайн түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн гарал, үүслийн талаарх мэдээллийг бичнэ.

7.1.23. **Бүтээлчийн нэр:** Тухайн түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн бүтээлч, зохиогчийн овог, нэрийг баримт, судалгааг үндэслэн бичнэ. Зохиогч, бүтээгч нь тодорхойгүй бол бөглөхгүй.

7.1.24. **Дэг сургууль хийц:** Тухайн түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг ямар "сургууль хийц"-д хамрагдахыг тогтоосон бол бичнэ. Тухайлбал: Монгол дархны урлал нь хийцээрээ Боржигин, Дарьганга, Долнуур, Ханхөхий, Буриад, Арчуул, Ноёнсэврэй, Авдарбаян, Батноров гэх мэт ангилагдсан байдаг.

7.1.25. **Материал:** Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг хийсэн үндсэн материалыг сонгоно. Хэрэв олон төрлийн материал болон эрдэнийн чулуу, үнэт металл орсон бол дараагийн талбарт тоочин бичиж болно.

7.1.26. **Арга ажиллагаа:** Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг хийсэн "арга ажиллагаа" нь тодорхой, танигдсан мэдээллийг бичнэ. Яаж хийсэн гэдгийг тодорхойлох, оёсон, цутгасан, будсан, хэвлэсэн гэх мэтээр тодорхой бичнэ.

7.1.27. **Тодорхойлолт:** Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн өнгө, хэлбэр төрх, материал, ур хийц, гараар болон үйлдвэрийн аргаар хийсэн болохыг тодорхой оновчтой дүрслэн бичнэ. Тухайлбал: дурсгалын үнэт металл, эрдэнийн чулууны тоо ширхэг, материалын өнгө, өөрчлөлт, хувирал зэргийг бичиж болно:

7.1.27.1. **дүрслэн бичих:** Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн хэлбэр төрх, өнгө, дүрс зэрэг нүдэнд харагдаж байгаа физик шинжийг оновчтой үгээр, үнэн зөв тодорхойлон бичнэ;

7.1.27.2.**тэмдэг бичээс:** Таних тэмдэг, он, дардас, тамга, бичиг, бичээс, сорьцын тэмдэглэгээ зэргийг бичнэ;

7.1.27.3.**ялгагдах онцлог:** Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн ялгагдах онцлог шинж тэмдгийн мэдээллийг бичнэ;

7.1.27.4.**зориулалт:** Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн язгуур зориулалт болон хэрхэн ашиглагдаж ирснийг бичнэ.

7.1.28.**Ерөнхий хэмжээ:** Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн ерөнхий өндөр, өргөн, урт, зузаан, голч, жинг бичнэ. Дурсгалын деталь хэсгүүдийн хэмжээг бусад хэмжээс хэсэгт бичнэ.

7.1.29.**Иж бүрдлийн бүрэлдэхүүн хэсгийн мэдээлэл:** Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл нь олон хэсгээс бүрдэж байгаа бол нэмэх товчлуур дээр даран иж бүрдэл бүрийг задлан бүртгэж болно. Бүртгэхдээ 7.1.14 дэх хэсгийн тоо, ширхгээс зөрөхгүй байх зарчмыг баримтална:

7.1.29.1.**хувийн дугаар:** Музейн үзмэр, эд өлгийн зүйлийн ерөнхий бүртгэлд бичигдсэн хувийн дугаарыг бичнэ;

7.1.29.2. иж бүрдлийн тодорхойлолтыг бичнэ;

7.1.29.3. иж бүрдлийн хэмжээг харгалзах утгуудад бичиж хадгална.

7.1.30.**Хадгалалтын байдал:** Тухайн түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн хадгалалтын байдалд үнэлгээ өгч харгалзах утгуудыг нөхнө:

7.1.30.1.**бүрэн бүтэн байдал:** Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл нь бүрэн бүтэн эсэх тухай бичнэ;

7.1.30.2.**чанар байдал:** Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн чанар байдлыг "сайн", "дунд", "муу" гэсэн сонголтоос тохирохыг сонгоно;

7.1.30.3.**гэмтэл:** Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн хаана нь ямар гэмтэлтэй болохыг тодорхой тоочин бичнэ.

7.1.31.**Цуглуулсан арга зам:** Музейн тухай хуулийн 12.2-заасны дагуу хайгуул, малтлага, судалгаагаар худалдаж авсан, өв бэлэглэлийн журмаар, эрх бүхий байгууллагын шийдвэрээр шилжүүлж авсан, өөрийн хөрөнгөөр бүтээлгэсэн хандив, тусламжаар авсан, хуулиар хориглоогүй бусад гэсэн сонголтоос аль хамаарахыг сонгоно:

7.1.31.1.**анхны үнэ:** Түүх соёлын хөдлөх дурсгалт зүйлийн анхны үнэлгээг бичнэ;

7.1.31.2.**бүтээлгэсэн үнэ:** Түүх соёлын хөдлөх дурсгалт зүйлийг шинээр бүтээлгэсэн бол үнийг бичнэ;

7.1.31.3.музейд авсан шийдвэрийн огноо дугаар: Музейд авсан шийдвэрийн огноо, дугаарыг бичнэ.

7.1.32.Товч түүх: Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн холбогдох газар, орон, хэрэглэж байсан хүн, цуглуулагч, бүтээлчийн түүхийг харгалзах утгад бичнэ:

7.1.32.1.холбогдох газар орон: Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн олдсон, эсвэл хэрэглэгдэж байсан газар орны тухай мэдээллийг бичнэ;

7.1.32.2.хэрэглэж байсан хүн: Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг хэрэглэж байсан хүнийг бичнэ;

7.1.32.3.цуглуулагчийн нэр: Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг цуглуулсан хүний нэрийг бичнэ;

7.1.32.4.бүтээлчийн нэр: Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг цуглуулсан хүнийг бичнэ.

7.1.33.Бүртгэлийн түүх: Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн хуучин хувийн дугаар болон ерөнхий бүртгэлийн дэс дугаар, бүртгэл, мэдээллийн сан дахь төрөлжсөн бүртгэлийн дугаар, үнэлгээний түүхийг харгалзах утгад бичнэ.

7.1.34.Хуучин хувийн дугаар: Холбогдох тушаал, шийдвэрийн дагуу шинээр хувийн дугаар өгсөн бол хувийн дугаарыг бичнэ.

7.1.35.Ерөнхий бүртгэлийн дэс дугаар: Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн ерөнхий бүртгэлийн дэвтэрт бүртгэгдсэн дэсийн дугаарыг бичнэ.

7.1.36.Төрөлжсөн бүртгэлийн дугаар: Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн төрөлжсөн бүртгэл дэх дэсийн дугаарыг бичнэ.

7.1.37.Үнэлгээний түүх: Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн үнэлгээг хэд хэдэн онд, ямар эрх бүхий байгууллагын шийдвэрээр, эсвэл тухайн байгууллага ямар шийдвэрийг үндэслэн нэмэх товчлуур даран гарч ирэх асуулгын дагуу бичнэ.

7.1.38.Судлагдсан байдал: Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн талаар гарсан ном зохиол, эрдэм шинжилгээний өгүүлэл, сонин сэтгүүл, нийтлэлийн нэр, зохиогч, оныг тоочин бичнэ.

7.1.39.Сэргээн засварлагдсан байдал: Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг сэргээн засварлагдсан эсэхийг "Тийм", "Үгүй" сонголтоос сонгоно. Хэрэв "Тийм" гэсэн сонголтыг сонгосон тохиолдолд "Нэмэх" товчийг дарж гарч ирэх цонхонд "Тайлангийн дугаар", "Сэргээн засварлагдсан газар", "Эхэлсэн, дууссан огноо", сэргээн засварласан тоо, ширхгийг бичнэ. Сэргээн засварлалт гэж устах, эвдрэх, гэмтэх аюул учирч байгаа соёлын өвийг авран хамгаалах зорилгоор сэргээн засварлах тусгай зөвшөөрөлтэй

иргэн аж, ахуй нэгж, байгууллагаар анхны эх төрхийг нь алдагдуулахгүйгээр механик ажилбар хийж, цэвэрлэгээ, бэхжүүлэлт, нөхөн сэргээх, засварлах үйл ажиллагааг хэлнэ.

7.1.40.Цэвэрлэгээ, бэхжүүлэлт хийгдсэн байдал: Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг цэвэрлэгээ бэхжүүлэлт хийгдсэн эсэхийг "Тийм", "Үгүй" сонголтоос сонгоно. Хэрэв "Тийм" гэсэн сонголтыг сонгосон тохиолдолд "Нэмэх" товчийг дарж гарч ирэх цонхонд "Цэвэрлэгээ хийгдсэн огноо", "цэвэрлэгдсэн тоо ширхэг"-ийг бичнэ.

Цэвэрлэгээ гэдэг нь соёлын биет өвд үүссэн төрөл бүрийн бохирдол, давхаргыг зогсоох арчлах, тордох үйл ажиллагааг хэлнэ.

Бэхжүүлэх гэдэг нь соёлын биет өвийг одоогийн эх төрх байдлаар нь хадгалах үйл ажиллагааг хэлнэ.

7.1.41.Хадгалалт хамгаалалт хийгдсэн байдал: Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн цэвэрлэгээ, бэхжүүлэлт хийгдсэн эсэхийг "Тийм", "Үгүй" сонголтоос сонгоно. Хэрэв "Тийм" гэсэн сонголтыг сонгосон тохиолдолд "Нэмэх" товчийг дарж гарч ирэх цонхонд Тайлангийн дугаар", "Хадгалалт хамгаалалт хийгдсэн газар", "эхэлсэн, дууссан огноо" "Хадгалалт хамгаалалт хийсэн тоо, ширхэг"-ийг тус тус бичнэ. Хадгалалт хамгаалалт гэж сэргээн засварлалт хийх шаардлагагүй материалын онцлогт таарсан стандарт орчин үүсгэх замаар хадгалалт хамгаалалт хийсэн дурсгалын мэдээллийг хэлнэ.

7.1.42.Үзэсгэлэнд оролцсон байдал: Дурсгалт зүйлийн гадаад, дотоод үзэсгэлэнд оролцсон эсэхийг "Тийм", "Үгүй" сонголтоос сонгоно. Хэрэв "Тийм" гэсэн сонголтыг сонгосон тохиолдолд "Нэмэх" товчийг дарж гарч ирэх цонхонд "Үзэсгэлэнгийн нэр", "Даатгалын байгууллага", "Даатгалын үнэ", "Дэлгэрэнгүй мэдээлэл"-ийг бичнэ.

7.1.43.Хуулбар хийгдсэн байдал: Дурсгалт зүйлийн хуулбар хийгдсэн эсэх, хуулбар хийгдсэн бол "Тийм", "Үгүй" сонголтоос сонгоно. Хэрэв "тийм" гэсэн сонголтыг сонгосон тохиолдолд "нэмэх" товчийг дарж гарч ирэх цонхонд "он", "Шийдвэрийн дугаар", "Хувилсан тоо ширхэг", "Гэрээний дугаар"-ийг бичнэ.

7.1.44.Мерчендайз хийгдсэн байдал: Дурсгалт зүйлийн Мерчендайз хийгдсэн эсэхийг "Тийм", "Үгүй" сонголтоос сонгоно. Хэрэв "тийм" гэсэн сонголтыг сонгосон тохиолдолд "нэмэх" товчийг дарж гарч ирэх цонхонд "он", "Шийдвэрийн дугаар", "Үйлдвэрлэсэн тоо ширхэг", "Гэрээний дугаар"-ийг бичнэ.

7.1.45.Шилжилт хөдөлгөөн: Тухайн дурсгалт зүйлийн шилжилт хөдөлгөөнд орсон бол "нэмэх" товчийг дарж гарч ирэх цонхонд "Шилжилт хөдөлгөөний төрөл", "Шилжилт хөдөлгөөний дэд төрөл", "Шилжсэн байгууллага", "Он", "Шийдвэрийн дугаар", "Дэлгэрэнгүй мэдээлэл" -ийг тус тус бичнэ.

7.1.46.Бүртгэл мэдээллийн санд хадгалагдаж байгаа баримт материал: Дурсгалын бүртгэл, мэдээллийн санд хадгалагдаж буй баримт, материалыг баримтын төрлөөс сонгон агуулга, хадгаламжийн нэгжийн дугаарыг бичнэ.

7.1.47. Төлөв өөрчлөлтийн түүх: Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэлийн дэд системд шинээр бүртгэсэн, бүртгэл баталгаажуулсан, засвар хийсэн хэрэглэгчийн мэдээллийн хамт харуулна.

7.1.48.Бүртгэн баримтжуулалтын гэрэл зураг: Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг бүртгэх, баримтжуулах болон тооллогоор авсан гэрэл зургийг оруулахдаа тухайн талбар дахь мэдээллийг бүрэн бөглөж гэрэл зургийн тохирох шошгыг сонгон оруулна. Зургийн хэмжээ нь 10MB илүүгүй, JPG, PNG өргөтгөлтэй байна.

7.1.49.Уран сайхны гэрэл зураг: GLAM системээр дамжуулан харуулах түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн уран сайхны зургийг оруулна. Зургийн хэмжээ нь 10MB илүүгүй, JPG, PNG өргөтгөлтэй байна.

7.1.50.Дүрс бичлэг: Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн холбогдолтой дуу дүрс бичлэг, контентыг оруулна. Оруулах бичлэгийн хэмжээ нь 100MB илүүгүй, mp4 өргөтгөлтэй байна.

7.1.51.3D файл: Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн 3D хэлбэрээр бүртгэн баримтжуулсан бол (OBJ) хэмжээсээр оруулна.

7.1.52.Улсын тооллогын мэдээлэл: Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 26.1 дэх хэсэгт заасны дагуу Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллогод хамрагдсан эсэхийг энэ хэсэгт бүртгэнэ. Тооллогод хамрагдсан эсэхийг бүртгэхдээ "Нэмэх" товчийг сонгон гарч ирсэн утгыг бөглөнө:

7.1.52.1.улсын тооллого: Тухайн оны тооллогын тушаал, шийдвэрээс тохирохыг сонгоно;

7.1.52.2.тооллого эхэлсэн он, дууссан он: Тухайн тооллогын эхэлсэн дууссан огноо бичнэ;

7.1.52.3.тооллогод хамрагдсан байдал: Тооллогод хамрагдсан байдлыг "Тийм", "Үгүй" сонголтоос аль тохирохыг сонгоно. "Тийм" гэсэн сонголтыг сонгосон тохиолдолд тоологдсон он, сар, өдрийг календариас сонгоно. "Үгүй" гэсэн сонголтыг сонгосон тохиолдолд тооллогод хамрагдаагүй шалтгааныг тайлбар хэсэгт оруулна.

7.2.Үзэсгэлэнгийн бүртгэл нь үндсэн мэдээлэл болон хавсралт файл гэсэн хэсгээс бүрдэнэ.

7.2.1.Тушаал шийдвэрийн дугаар: Тухайн үзэсгэлэн гаргах тухай тушаал, шийдвэрийн огноо, дугаарыг бичнэ.

7.2.2. Үзэсгэлэнгийн төрөл: Тухайн түүх, соёлын дурсгалт зүйл нь “Гадаад” “Дотоод”-ын үзэсгэлэнгийн алинд оролцсон болохыг сонгоно:

7.2.2.1. улсын нэр: Аргачлалын 7.2.2. дахь үзэсгэлэнгийн төрлөөс “Гадаад” гэсэн сонголтыг хийсэн тохиолдолд үзэсгэлэн зохион байгуулагдсан улсын нэрийг сонгоно.

7.2.2.1. үзэсгэлэн зохион байгуулагдсан газар: Аргачлалын 7.2.2. дахь үзэсгэлэнгийн төрлөөс “Дотоод” гэсэн сонголтыг хийсэн тохиолдолд тухайн үзэсгэлэн зохион байгуулагдсан газрын нэрийг бичнэ.

7.2.3. Үзэсгэлэнгийн нэр: Тухайн үзэсгэлэнгийн нэрийг бичнэ.

7.2.4. Үзэсгэлэнгийн хугацаа: Үзэсгэлэн эхэлсэн, дууссан огноог календариас сонгоно.

7.2.5. Даатгалын үнэ: Үзэсгэлэнд оролцуулахдаа даатгуулсан үнийн дүнг төгрөгөөр бичнэ.

7.2.6. Үзэсгэлэнд оролцсон: Үзэсгэлэнд оролцсон байгууллагын нэрийг сонгоно.

7.2.7. Хавсралт файл: Нэмэх товчлуурыг дарж тухайн үзэсгэлэнгийн холбогдолтой баримт материалыг тайлбар бичиж PDF хэлбэрээр оруулна.

7.3. Түүх соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тайлан

7.3.1. Түүх соёлын хөдлөх дурсгалт зүйлийн нийт тоон дүн:

Системд бүртгэгдсэн хөдлөх дурсгалт зүйлийн дэс, тоо, ширхэг, иж бүрдлийн бүрэлдэхүүн хэсгийн тоо, бүртгэлийн үнийн нийт тоон дүнг гаргана.

7.3.2. Түүх соёлын хөдлөх дурсгалт зүйлийн нийт төрөл зүйлийн тоон дүн:

Системд бүртгэгдсэн хөдлөх дурсгалт зүйлийг 6 төрөл зүйлээр ангилан дэс, тоо, ширхгийг гаргана.

7.3.3. Үзэсгэлэнд оролцсон үзмэрийн тоон дүн:

Системд бүртгэгдсэн түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг “Гадаад”, “Дотоод” гэсэн төрлөөр ангилан дэс, тоо ширхэг, үнийн дүнг гаргана.

7.3.4. Үзэсгэлэнд оролцсон үзмэрийн нийт төрөл зүйлийн тоон дүн:

Системд бүртгэгдсэн түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг “Гадаад”, “Дотоод” гэсэн төрөл болон 6 төрөл зүйлийн ангиллаар дэс, тоо ширхгийн тоон дүнг гаргана.

7.3.5. Хасагдсан үзмэрийн мэдээллийн нийт тоон дүн:

Системд бүртгэгдсэн түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг:

- Шилжүүлсэн,

- Хасаж акталсан,
- Хулгайд алдсан,
- Дутсан,
- Солигдсон,
- Үрэгдсэн,
- Бусад шалтгаан тодорхойгүй гэсэн үзүүлэлтийн дагуу 6 төрөл зүйлийн ангиллаар дэс тоо ширхгийн тоон дүн үнэлгээг гаргана.

7.3.6.Хасагдсан үзмэрийн жагсаалт:

Системд бүртгэгдсэн түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг өмчлөгч, эзэмшигчээр нь:

- Шилжүүлсэн,
- Хасаж акталсан,
- Хулгайд алдсан,
- Дутсан,
- Солигдсон,
- Үрэгдсэн,
- Бусад шалтгаан тодорхойгүй гэсэн үзүүлэлтийн дагуу төрөл зүйлийн 6 ангилал тус бүрээр дэс тоо ширхгийн тоон дүн, үнэлгээг жагсаалтаар гаргана.

7.3.7.Нэмэгдсэн түүх соёлын хөдлөх дурсгалт зүйлийн нийт тоон дүн:

Тоон дүнг:

- Музейн хайгуул, малтлага, судалгааны ажлын үр дүнд олж авсан,
- Худалдаж авсан,
- Өв, бэлэглэлийн журмаар авсан,
- Эрх бүхий байгууллагын шийдвэрээр шилжүүлж авсан,
- Өөрийн хөрөнгөөр бүтээлгэсэн,
- Хандив, тусламжаар авсан ,
- Хуулиар хориглоогүй бусад гэсэн үзүүлэлтийн дагуу өмчлөгч, эзэмшигчээр болон дэс тоо ширхгээр гаргана.

7.3.8.Нэмэгдсэн түүх соёлын хөдлөх дурсгалт зүйлийн жагсаалт:

Системд тухайн онд шинээр нэмж бүртгэгдсэн түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тоон дүнг:

- Музейн хайгуул, малтлага, судалгааны ажлын үр дүнд олж авсан,
- Худалдаж авсан,
- Өв, бэлэглэлийн журмаар авсан,
- Эрх бүхий байгууллагын шийдвэрээр шилжүүлж авсан,
- Өөрийн хөрөнгөөр бүтээлгэсэн,
- Хандив, тусламжаар авсан,
- Хуулиар хориглоогүй бусад гэсэн үзүүлэлтээр холбогдох хүснэгтийн дагуу жагсаалтаар гаргана.

7.3.9.Сэргээн засварлагдсан үзмэрийн мэдээлэл:

Энэ хэсэг нь:

- Сэргээн засварлагдсан үзмэрийн мэдээлэл-1. Сэргээн засварлагдсан,
- Сэргээн засварлагдсан үзмэрийн мэдээлэл-2. Цэвэрлэгээ бэхжүүлэлт хийгдсэн,

- Сэргээн засварлагдсан үзмэрийн мэдээлэл-3. Хадгалалт хамгаалалт хийгдсэн гэсэн 3 хэсэгт бүртгэгдсэн мэдээллээс боловсруулагдаж өмчлөгч, эзэмшигч болон нэр, хувийн дугаар, төрөл зүйл, үнэлгээг дэс, тоо ширхгээр гаргана.

Найм. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын дэд системд
бүртгэл хөтлөх

8.1.Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын бүртгэл нь үндсэн мэдээлэл, хадгалалт хамгаалалтын мэдээлэл, нэмэлт мэдээлэл, медиа сан, судалгааны мэдээлэл тооллогын мэдээлэл гэсэн хэсгээс бүрдэнэ.

8.1.1.**УНБСангийн дугаар:** Дурсгалт газрын мэдээллийг бүрэн оруулсны дараа систем автоматаар бүртгэлийн дугаарыг өгнө. (ҮД-үл хөдлөх, 112600001 аймаг/нийслэлийн 2 орон код + сум/дүүргийн 2 орон код + 4 орон нь тухайн сум дүүрэгт бүртгэгдсэн дурсгалт газрын дэс дугаар+1 орон нь дурсгалт газрын төрөл зүйлийн дугаар байна).

8.1.2. **Засаг, захиргааны нэгж:** Дурсгалт газрын оршин байгаа, харьяалах аймаг, нийслэл болон сум дүүргийг сонгоно.

8.1.3.**Дурсгалт газрын нэр:** Дурсгалт газрын нэрийг бичнэ. Ингэхдээ нийтэд нэршиж заншсан нэрийг бичих зарчмыг баримтална. Хэрэв хэд хэдэн нэрээр нийтэд түгсэн бол шинжлэх ухааны эргэлтэд орсон хамгийн түгээмэл нэрийг эсвэл хамгаалалтын зэрэглэлд батлагдсан нэрийг бичнэ. Шинээр дурсгалт газар бүртгэж байгаа бол хамгийн ойрын газар, усны нэрийг ашиглана.

8.1.4.**Төрөл зүйл:** Дурсгалт газрын төрөл зүйлийг сонгохдоо үндсэн болон дэд төрөл зүйлийн тохирохыг сонгоно (ингэхдээ хоёр ба түүнээс дээш төрөл зүйлийн дурсгалтай бол үнэ цэнэ ач холбогдлыг харгалзан сонгоно).

8.1.5.**Бүртгэгдсэн эх сурвалж:** Дурсгалт газрыг аймгийн музейн судалгаагаар илрүүлсэн бол “музейн хайгуул судалгаагаар”; соёлын өвийн судалгаа хийх зөвшөөрөл бүхий эрдэм шинжилгээний байгууллагын мэдээллээр илрүүлсэн бол “эрдэм, шинжилгээ судалгааны байгууллагын мэдээллээр”; иргэдийн мэдээллээр илрүүлсэн бол “иргэдийн мэдээллээр”; дээр дурдсанаас өөр эх сурвалжаар илрүүлсэн бол “бусад эх сурвалжийн мэдээллээр” гэснээс тохирохыг сонгоно.

8.1.6.**Тодорхойлолт:** Дурсгалт газрын орон зайн байршлыг (аймгийн төвөөс аль зүгт хэдэн км, сумын төвөөс аль зүгт хэдэн км) хүрээлэн буй орчин тухайн дурсгалт газарт ямар төрөл зүйлийн хэдэн дурсгал байгааг, дурсгалын тархац г.м дэлгэрэнгүй мэдээллийг бичнэ.

8.1.7.**Олон нийтэд зориулсан тайлбар:** Дурсгалт газрын засаг, захиргааны нэгж, төрөл зүйл, холбогдох он цаг, ач холбогдол, онцлог болон дэлхийн өв, хамгаалалтын зэрэглэлд бүртгэгдсэн талаарх мэдээллийг багтаасан товч тайлбарыг бичнэ.

8.1.8.Тоо ширхэг: Дурсгалт газрын хамрах хүрээнд байгаа нийт дурсгалын тоог бичнэ.

8.1.9.Хамгаалалтын зэрэглэл: Дурсгалт газар нь улс, аймаг, нийслэл, сум дүүргийн хамгаалалтад бүртгэгдсэн бол тохирохыг, ямар нэгэн хамгаалалтын зэрэглэлд бүртгэгдээгүй бол хамгаалалтад аваагүй гэснийг сонгоно.

8.1.10.Хамгаалалтад авсан тушаал, шийдвэр: Улсын хамгаалалттай бол Засгийн газрын тогтоолыг, аймаг, нийслэлийн хамгаалалттай бол Соёлын сайдын тушаалыг, Сум, дүүргийн хамгаалалттай бол аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоолыг тус тус сонгоно.

8.1.11.Сэргээн засварласан мэдээлэл: Дурсгалт газарт байх дурсгалын эх төрх байдлыг нь сэргээн засварласан бол ямар төрлийн дурсгалыг, хэдэн онд, ямар байгууллага сэргээн засварласан тухай дэлгэрэнгүй бичнэ.

8.1.12.Дэлхийн өвийн дурсгалт газрын хамгаалалтын бүсэд орсон эсэх: Дурсгалт газар нь Монгол Улсаас ЮНЕСКО-ийн Дэлхийн өвд бүртгэгдсэн бол "Тийм" гэснийг сонгон тэмдэглэл хэсэгт Дэлхийн өвийн дурсгалт газрын хамгаалалтын бүсэд орсон тогтоол, шийдвэр, холбогдох мэдээллийг бичнэ. Бүртгэгдээгүй бол "Үгүй" гэснийг сонгоно.

8.1.13.Орон зайн мэдээлэл: Энэ хэсэгт дурсгалт газрын солбицол болон хамрах хүрээний солбицлыг тус тус оруулна:

8.1.13.1.солбицол: WGS 84 солбицол уртраг (N), өргөрөг (E)-ийн хэм (°), минут ('), секунд (")-ын утгаар солбицлыг тухайн дурсгалт газрын төв цэгт байршлыг тодорхойлж утгыг оруулна,

8.1.13.2.хамрах хүрээний солбицол: Дурсгалт газар болон дурсгал байрлаж буй нийт талбайн захын солбицлыг бичнэ. Хамрах хүрээ нь тухайн дурсгалт газарт байгаа дурсгалын нийт талбайг оруулан, гадна талаар нь хязгаарлалт үүсгэсэн орон зайг хэлнэ (хязгаарын цэгийн солбицлыг хэмжиж тэмдэглэхдээ эхний сонгосон цэгээс нар зөв тойрох зарчмыг баримтална).

8.1.14.Дурсгалт газрыг гэрээт харуул хамгаалдаг эсэх: Дурсгалт газрыг иргэн, аж ахуй нэгжтэй байгуулсан гэрээний үндсэн дээр хяналт тавиулж, хариуцуулж байгаа тохиолдолд "Тийм" гэснийг, гэрээт харуулгүй бол "Үгүй" гэснийг сонгоно:

8.1.14.1.хамгаалалтын мэдээлэл: Аргачлалын 8.1.14. Дурсгалт газрыг гэрээт харуул хариуцдаг буюу "Тийм" гэснийг сонгосон бол нэмэх товчийг дарж иргэн, аж ахуй нэгжтэй байгуулсан гэрээний огноо, гэрээ дуусах огноог оруулан, тэмдэглэл хэсэгт гэрээ байгуулсан иргэн болон аж ахуй нэгжийн тухай мэдээллийг дэлгэрэнгүй бичнэ.

8.1.15.Хашаа хайстай эсэх: Дурсгалт газар болон дурсгалыг гаднын нөлөөнөөс хамгаалах хашаа хайстай бол “Тийм” гэснийг сонгон хашаа хайсыг хийсэн оныг оруулан, тэмдэглэл хэсэгт хэмжээ болон материалын талаар, ямар санхүүжилтээр хийгдсэн тухай дэлгэрэнгүй бичнэ. Хэрэв хамгаалах хашаа хайсгүй бол “Үгүй” гэснийг сонгоно (үгүй гэсэн сонголтыг сонгосон бол Хашаа хайс нь хадгалалт хамгаалалтын нөхцөлийг хангаж байгаа эсэх, Хашаа хайс бүрэн бүтэн эсэх гэсэн асуулгууд идэвхжихгүй):

8.1.15.1.хашаа хайс нь хадгалалт хамгаалалтын нөхцөлийг хангаж байгаа эсэх: Аргачлалын 8.1.15. Дурсгалт газар болон дурсгалыг хамгаалах зорилгоор босгосон хашаа нь мал амьтан, салхи шуурга зэрэг байгалийн нөлөөгөөр унавал дурсгалд гэмтэл учруулахуйц нөхцөл байдалд байгаа бол “Үгүй” гэснийг сонгон тэмдэглэл хэсэгт ямар сөрөг нөлөө үзүүлж болзошгүй байгааг дэлгэрэнгүй бичнэ. Ямар нэгэн эрсдэл учруулахааргүй байвал “Тийм” гэснийг сонгоно,

8.1.15.2.хашаа хайс бүрэн бүтэн эсэх: Аргачлалын 8.1.15. Хашаа хайс нь ямар нэг байдлаар эвдэрсэн, нурсан, аль нэг хэсэг нь байхгүй болсон бол “үгүй” гэснийг сонгон тэмдэглэл хэсэгт ямар гэмтэл үүссэнийг дэлгэрэнгүй бичнэ. Хашаа хайс нь бүрэн бүтэн бол “Тийм” гэснийг сонгоно.

8.1.16.Хаяг тайлбартай эсэх: Дурсгалт газрын талаарх мэдээллийг агуулсан танилцуулга бүхий хаяг тайлбартай бол “Тийм” гэснийг сонгон тэмдэглэл хэсэгт хаяг тайлбар хийсэн он, хэмжээ, санхүүжилт зэрэг мэдээллийг бичнэ. Хаяг тайлбаргүй бол “Үгүй” гэснийг сонгоно.

8.1.17.Кадастрын хэмжилт хийсэн эсэх: Холбогдох мэргэжлийн байгууллагаар хэмжилт, зураглал хийлгэсэн бол “Тийм” гэснийг сонгон тэмдэглэл хэсэгт ямар аж ахуй нэгжээр хэзээ хийлгэсэн тухай мэдээллийг бичнэ. Хэмжилт хийгээгүй бол “Үгүй” гэснийг сонгоно.

8.1.18.Газрын кадастрын улсын бүртгэлд бүртгэгдсэн эсэх: Кадастрын хэмжилтийн мэдээллийг газрын кадастрын улсын бүртгэлд бүртгүүлсэн бол “Тийм” гэснийг сонгон тэмдэглэл хэсэгт нэгж талбайн дугаар болон гүйцэтгэсэн байгууллага, огноог бичнэ. Бүртгүүлээгүй бол “Үгүй” гэснийг сонгоно.

8.1.19.Хадгалалт хамгаалалтын эрсдэлд өртсөн байдал: Дурсгалын анхны хэлбэр төрөхөд хүний буруутай үйл ажиллагаа болон байгалийн хүчин зүйлийн нөлөөгөөр гэмтэл учирсан бол “гэмтсэн”, дурсгалыг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй, хууль бусаар зөөж шилжүүлсэн бол “зөөгдсөн”, дурсгалын бүрэн бүтэн байдлыг алдагдуулсан, хууль бусаар тоносон бол “тоногдсон”, дурсгалт газрыг бүрдүүлж байгаа дурсгал (хэсгүүд) нь алга болсон бол “алга болсон” гэснээс тохирохыг сонгоно. Дээрх сонголт тохирохгүй бол бөглөхгүй байж болно.

8.1.20.Бүртгэн баримтжуулалтын гэрэл зураг: Гэрэл зургийг оруулахдаа тухайн талбар дахь мэдээллийг бүрэн бөглөж гэрэл зургийн тохирох шошгыг

сонгон, гэрэл зураг бүрд тайлбар бичнэ. Оруулах зургийн хэмжээ нь 10MB илүүгүй, JPG, PNG өргөтгөлтэй байна.

8.1.21. **Уран сайхны зураг:** Дурсгалт газрын болон дурсгалын нягтаршил сайн зураг оруулна. Оруулах зургийн хэмжээ нь 10MB илүүгүй, JPG, PNG өргөтгөлтэй байна.

8.1.22. **Дүрс бичлэг:** Дурсгалт газартай холбоотой дүрс бичлэг оруулна. Оруулах бичлэгийн хэмжээ нь 100MB илүүгүй, mp4 өргөтгөлтэй байна. Байхгүй бол оруулахгүй байж болно.

8.1.23. **Дурсгалыг анх нээж, илрүүлсэн тухай мэдээлэл:** Дурсгалт газрыг анх ямар эх сурвалжийн мэдээллээр нээж ирүүлсэн тухай бичнэ. Хэрэв эрдэм шинжилгээний байгууллагын мэдээллээр ирүүлсэн бол байгууллагын нэр, төслийн нэрийг, иргэний мэдээллээр илрүүлсэн бол тухайн хүний мэдээллийг дэлгэрэнгүй бичнэ.

8.1.24. **Товч түүх:** Дурсгалт газартай холбоотой түүхэн баримт, судалгааны үр дүн, аман яриа, зан үйлийн талаарх мэдээллийг болно.

8.1.25. **Нэмэлт мэдээлэл:** Дурсгалт газартай холбоотой бусад мэдээллийг бичиж болно.

8.1.26. **Судалгаатай холбоотой мэдээлэл:** Дурсгалт газрын талаарх судалгаатай холбоотой цахим файлыг (өгүүлэл, ном г.м) оруулахдаа нэмэх товчийг дарж гарч ирэх цонхон дахь мэдээллийг бүрэн бөглөж бичнэ.

8.1.27. **Тооллогод хамрагдсан эсэх:** Соёлын өвийг хамгаалах тухай хуульд заасны дагуу түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тооллогод хамрагдсан бол "Тийм" гэснийг, хамрагдаагүй бол "Үгүй" гэснийг сонгон холбогдох мэдээллийг бүрэн оруулна.

- **Тооллогын нэр:** Тухайн оны тооллогын нэрийг сонгоно.
- **Дэлгэрэнгүй мэдээлэл:** Дурсгалд гэмтэл учруулж буй нөлөөлөх хүчин зүйлс болон тооллогын үеийн мэдээллийг бичнэ.
- **Тооллогод хамрагдсан огноо:** Тооллогод хамруулсан огноог оруулна. Тооллогод хамрагдаж байгаагүй бол хадгалалт хамгаалалтын үнэлгээ хийсэн огноог оруулна.
- **Гэмтлийн мэдээлэл:** Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын төрөл зүйл тус бүрд тохирох гэмтлийн асуулгыг тохирох хувиар газар дээр нь үнэлсэн үнэлгээг оруулна. (Дурсгалт газар болон дурсгалын төрөл зүйл тус бүрийн онцлогт тохирсон гэмтлийн Асуулга, тайлбарыг оруулав.)

Асуулга, тайлбар

Д/д	Гэмтлийн төрөл	Тайлбар
1	Аж ахуйн нөлөөлөлд өртсөн эсэх	Тухайн дурсгалт газар аж ахуйн нөлөөлөлд өртөөгүй бол "Гэмтэлгүй", харин харин ийм үйл ажиллагаа явагдсан бол нийт дурсгалын тоотой харьцуулан "10% хүртэл", "10-50% хүртэл", "50% дээш" сонголтуудаас тохирохыг сонгоно.

2	Байгалийн өгөршил, элэгдэлтэд өртсөн эсэх:	Тухайн дурсгалт газарт Байгалийн өгөршил, элэгдэлтэд өртөөгүй бол "Гэмтэлгүй", харин Байгалийн өгөршил, элэгдэлтэд өртсөн бол нийт талбайн хэмжээтэй нь харьцуулан "10% хүртэл", "10-50% хүртэл", "50% дээш" сонголтуудаас тохирохыг сонгоно.
3	Биологийн бохирдол (Хаг, сангас, ургамал...)	Тухайн дурсгалт газарт биологийн бохирдол байхгүй бол "Гэмтэлгүй", харин ийм төрлийн гэмтэл тохиолдож байгаа бол нийт дурсгалын тоо хэмжээтэй нь харьцуулан "10% хүртэл", "10-50% хүртэл", "50% дээш" сонголтуудаас тохирохыг сонгоно.
4	Будаж балласан (Хүний үйл ажиллагаа) эсэх:	Тухайн дурсгалт газарт будаж балласан тохиолдол байхгүй бол "Гэмтэлгүй", харин ийм төрлийн гэмтэл тохиолдож байгаа бол нийт дурсгалын тоо хэмжээтэй нь харьцуулан "10% хүртэл", "10-50% хүртэл", "50% дээш" сонголтуудаас тохирохыг сонгоно.
5	Булшны дараас чулуу газрын хөрсөнд дарагдсан эсэх	Булшны дараас чулуу газрын хөрсөнд ямар нэг байдлаар дарагдаагүй бол "Гэмтэлгүй", харин ийм байдал үүссэн бол нийт дурсгалын тоотой харьцуулан "10% хүртэл", "10-50% хүртэл", "50% дээш" сонголтуудаас тохирохыг сонгоно.
6	Буруу сэргээн засварлалт хийсэн эсэх:	Тухайн дурсгалыг сэргээн засварлаагүй бол "Гэмтэлгүй", харин дурсгалд ийм төрлийн үйл ажиллагаа хийсэн бол дурсгалын бүрэн бүтэн, эх төрхтэй нь харьцуулан "10% хүртэл", "10-50% хүртэл", "50% дээш" сонголтуудаас тохирохыг сонгоно.
7	Газар тариаланд өртсөн эсэх:	Тухайн дурсгалт газарт газар тариалан эрхлэх үйл ажиллагаа явагдаагүй бол "Гэмтэлгүй", харин ийм үйл ажиллагаа явагдсан бол нийт талбайн хэмжээтэй нь харьцуулан "10% хүртэл", "10-50% хүртэл", "50% дээш" сонголтуудаас тохирохыг сонгоно.
8	Дурсгалт газраас элс шороо авдаг эсэх:	Тухайн дурсгалт газраас элс шороо авах үйл ажиллагаа явагдаагүй бол "Гэмтэлгүй", харин ийм үйл ажиллагаа явагдсан бол нийт талбайн хэмжээтэй нь харьцуулан "10% хүртэл", "10-50% хүртэл", "50% дээш" сонголтуудаас тохирохыг сонгоно.
9	Жуулчны баазтай ойр эсэх:	Тухайн дурсгалт газраас 5 км-ээс хол зайд Жуулчны бааз байвал "Гэмтэлгүй", харин дурсгалт газартай 5-3 км зайд байвал "10% хүртэл", 3-1 км байвал "10-50% хүртэл", 1 км ээс дотор "50% дээш" гэсэн сонголтыг хийнэ.
10	Орон нутгийн чанартай замд өртсөн эсэх:	Тухайн дурсгалт газар дээгүүр орон нутгийн чанартай зам дайрч гараагүй бол "Гэмтэлгүй", харин дурсгалт газраар зам ямар нэг хэмжээгээр дайрсан байвал өртсөн талбайн хэмжээтэй нь харьцуулан "10% хүртэл", "10-50% хүртэл", "50% дээш" сонголтуудаас тохирохыг сонгоно.
11	Объектын гал түймэрт өртсөн эсэх:	Тухайн дурсгал объектын түймэрт өртөөгүй бол "Гэмтэлгүй", харин ийм тохиолдол байгаа бол нийт байгууламжийн тоо, хэмжээтэй нь харьцуулан "10%

		хүртэл", "10-50% хүртэл", "50% дээш" сонголтуудаас тохирохыг сонгоно.
12	Өгөршсөн эсэх:	Тухайн дурсгалт газарт өгөршсөн тохиолдол байхгүй бол гэмтэлгүй буюу "Гэмтэлгүй", харин ийм төрлийн гэмтэл тохиолдож байгаа бол нийт дурсгалын тоо хэмжээтэй харьцуулан "10% хүртэл", "10-50% хүртэл", "50% дээш" сонголтуудаас тохирохыг сонгоно.
13	Өөх, тосны бохирдол (Хүний үйл ажиллагаа) эсэх:	Тухайн дурсгалт газарт өөх, тосны бохирдол байхгүй бол "Гэмтэлгүй", харин ийм төрлийн гэмтэл тохиолдож байгаа бол нийт дурсгалын тоо хэмжээтэй нь харьцуулан "10% хүртэл", "10-50% хүртэл", "50% дээш" сонголтуудаас тохирохыг сонгоно.
14	Суурьшлын бүс, газар олголтод өртсөн эсэх:	Тухайн дурсгалт газар суурьшлын бүс, газар олголтод өртөөгүй бол "Гэмтэлгүй", харин ийм үйл ажиллагаа явагдсан бол нийт талбайн хэмжээтэй нь харьцуулан "10% хүртэл", "10-50% хүртэл", "50% дээш" сонголтуудаас тохирохыг сонгоно.
15	Сийлж сүйтгэсэн (Хүний үйл ажиллагаа) эсэх:	Тухайн дурсгалт газарт сийлж сүйтгэсэн тохиолдол байхгүй бол "Гэмтэлгүй", харин ийм төрлийн гэмтэл тохиолдож байгаа бол нийт дурсгалын тоо хэмжээтэй нь харьцуулан "10% хүртэл", "10-50% хүртэл", "50% дээш" сонголтуудаас тохирохыг сонгоно.
16	Ухагдсан, тоногдсон эсэх	Тухайн дурсгалт газарт тоногдсон дурсгал огт байхгүй бол "Гэмтэлгүй", харин харин ийм үйл ажиллагаа явагдсан бол нийт дурсгалын тоотой харьцуулан "10% хүртэл", "10-50% хүртэл", "50% дээш" сонголтуудаас тохирохыг сонгоно.
17	Хагарал, цууралттай эсэх:	Тухайн дурсгалт газарт хагарал, цуурал байхгүй бол "Гэмтэлгүй", харин ийм төрлийн гэмтэл тохиолдож байгаа бол нийт дурсгалын тоо хэмжээтэй нь харьцуулан "10% хүртэл", "10-50% хүртэл", "50% дээш" сонголтуудаас тохирохыг сонгоно.
18	Хазайсан эсэх:	Тухайн дурсгал огт хазайгаагүй бол "Гэмтэлгүй", харин бага зэрэг хазайсан байвал "10% хүртэл", хазайсан боловч газрын хөрсөн дээр унаагүй байвал "10-50% хүртэл", газрын хөрсөн дээр хэвтээгээр унасан байвал "50% дээш" гэсэн үнэлгээг сонгоно.
19	Хог хаясан эсэх:	Тухайн дурсгалт газарт ямар нэгэн хог хаяагүй бол "Гэмтэлгүй", харин хог хаягдсан бол хогийн хэмжээг нийт талбайн хэмжээтэй нь харьцуулан "10% хүртэл", "10-50% хүртэл", "50% дээш" сонголтуудаас тохирохыг сонгоно.
20	Ховхорч унасан, зарим хэсэг нь алга болсон эсэх:	Тухайн дурсгалт газарт ховхорч унасан, зарим хэсэг нь алга болсон тохиолдол байхгүй бол гэмтэлгүй буюу "Гэмтэлгүй", харин ийм төрлийн гэмтэл тохиолдож байгаа бол нийт дурсгалын тоо хэмжээтэй нь харьцуулан "10% хүртэл", "10-50% хүртэл", "50% дээш" сонголтуудаас тохирохыг сонгоно.

21	Эрдэсжилт (хадан дээр шохойжилт үүссэн):	Тухайн дурсгалт газарт эрдэсжилт байхгүй бол "Гэмтэлгүй", харин ийм төрлийн гэмтэл тохиолдож байгаа бол нийт дурсгалын тоо хэмжээтэй нь харьцуулан "10% хүртэл", "10-50% хүртэл", "50% дээш" сонголтуудаас тохирохыг сонгоно.
22	Эх төрх байдлыг алдагдуулсан эсэх:	Тухайн дурсгал эх төрх байдлыг алдагдуулаагүй бол "Гэмтэлгүй", харин ийм тохиолдол байгаа бол нийт дурсгалын бүрэн бүтэн, эх төрхтэй нь харьцуулан "10% хүртэл", "10-50% хүртэл", "50% дээш" сонголтуудаас тохирохыг сонгоно.

Гэмтлийн мэдээллийн тоон дүнг нэгтгэх, үнэлэх аргачлал: Гэмтлийн мэдээллийн асуулга тус бүр дээр тэмдэглэгдсэн сонголтыг нэгтгэх байдлаар үнэлгээг хийнэ. Тухайлбал гэмтлийн мэдээллийн Гэмтэлгүй бол 0 оноо, 10 хүртэл хувийн 1 сонголт 1 оноо, 10-50 хүртэл хувийн 1 сонголт 2 оноо, 50% дээш хувийн 1 сонголт 3 онооны сонголт тус бүрийн нийлбэрээр тухайн дурсгалын гэмтлийн мэдээллийг 4 сонголтаар үнэлнэ. Жишээ нь 10% хүртэл багана дээр 4 сонголт хийгдсэн бол 1 тус бүрээр тоолж нэгдсэн дүнгийн хэсэгт 4, 10-50% хүртэл багана дээр 4 сонголт хийгдсэн бол 1 сонголтыг 2 гэж тоолж нэгдсэн дүнгийн хэсэгт 8, 50% дээш багана дээр 4 сонголт хийгдсэн бол 1 сонголтыг 3 гэж тоолж нэгдсэн дүнгийн хэсэгт 12 гэх мэт нэгтгэж төрөл тус бүрийн гэмтлийн мэдээллийн доор байгаа онооны үнэлгээнээс (□ 0-4 Сайн; □ 5-9 Дунд; □ 10-14 Муу; □ 15-18 Маш муу) сонголт хийж үнэлгээг гаргана.

8.2. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын бүртгэл

8.2.1. **УНБ Сангийн дугаар:** Дурсгалт газрын нэрийг сонгоод дурсгалын мэдээллийг оруулсны дараа систем автоматаар бүртгэлийн дугаарыг өгнө (ҮД-үл хөдлөх, 112600013100 аймаг/нийслэлийн 2 орон код + сум/дүүргийн 2 орон код + 4 орон нь тухайн сум дүүрэгт бүртгэгдсэн дурсгалт газрын дэс дугаар+1 орон нь дурсгалт газрын төрөл зүйлийн дугаар + 3 орон нь дурсгалын дэс дугаар байна).

8.2.2. **Дурсгалт газрын нэр:** Тухайн дурсгал оршин байгаа дурсгалт газрын нэрийг сонгоно (шинээр дурсгал бүртгэхдээ эхлээд дурсгалт газрын мэдээллийг оруулж бүртгэсний дараа дурсгал бүртгэнэ).

8.2.3. **Дурсгалын нэр:** Тухайн дурсгалын нэрийг бичнэ. Нэг төрөл зүйлийн олон тооны дурсгалыг бүлэглэж бүртгэж болно.

8.2.4. **Төрөл зүйл:** Дурсгалын үндсэн болон дэд төрөл зүйлийг сонгоно.

8.2.5. **Холбогдох он, цаг:** Дурсгалын хамаарах он цагийг байгалийн болон түүхийн гэсэн он цагийн үечлэлээс аль хамаарахыг сонгоно.

8.2.6. **Шилжилт хөдөлгөөний төрөл:** Тухайн дурсгал алга болсон, зөөгдсөн, шилжүүлсэн бол тохирохыг сонгоно.

8.2.7.Тодорхойлолт: Дурсгалын газарзүйн байршил (уулын энгэр, бэлд, голын хөндий г.м), гадаад зохион байгуулалт, дүрслэл, өнгө төрх, хийц маяг, материал зэргийг тодорхой бичнэ.

8.2.8.Олон нийтэд харуулах эсэх: Дурсгалыг олон нийтэд харуулах буюу GLAM систем рүү дамжуулах бол "Тийм" гэснийг дамжуулахгүй бол "Үгүй" гэснийг сонгоно.

8.2.9.Олон нийтэд зориулсан тайлбар: Дурсгалын талаарх олон нийтэд зориулсан тайлбар нь товч тодорхой байх бөгөөд, газар зүйн байршил, солбицол зэргийг бичихгүй.

8.2.10. Тоо ширхэг: Дурсгалын тоог тоон утгаар оруулна. Олон тооны дурсгалыг бүлэглэх байдлаар (булш оршуулгын дурсгал, хадны зураг г.м) оруулах бол хэдэн дурсгал байгааг тоолон оруулна.

8.2.11.Орон зайн мэдээлэл: Энэ хэсэг дурсгалын үндсэн солбицол болон хамрах хүрээг оруулна:

8.2.11.1.солбицол: WGS 84 солбицол уртраг (N), өргөрөг (E)-ийн хэм (°), минут ('), секунд (")-ын утгаар солбицлыг тухайн дурсгалын төв цэгт байршлыг тодорхойлж утгыг оруулна;

8.2.11.2.хамрах хүрээний солбицол: Дурсгалын нийт талбайг оруулан, гадна талаар хязгаарлалт үүсгэж хамрах хүрээг тодорхойлно. Хязгаарын цэгийн солбицлыг хэмжиж тэмдэглэхдээ эхний сонгосон цэгээс нар зөв тойрох зарчмыг баримтална;

8.2.11.3.өндөршил (ДТД): Дурсгал орших газрын өндөршлийг далайн түвшнээс дээш метрийн заалтаар тоон утгаар оруулна.

8.2.12.Ерөнхий хэмжээ: Дурсгалын ерөнхий хэмжээг бичнэ. Тухайн дурсгалт газар байх олон дурсгалуудын дундаж, хамгийн том ба хамгийн жижиг хэмжээг бичиж болно.

8.2.13.Бүртгэн баримтжуулалтын гэрэл зураг: Дурсгалт газрын ерөнхий зураг болон дурсгалт газарт байх дурсгалыг бүртгэх, баримтжуулах, тооллогоор авсан гэрэл зургийг оруулна. Гэрэл зураг оруулахдаа зураг оруулах товчийг дарж гарч ирэх цонхон дахь мэдээллийг бүрэн бөглөж гэрэл зургийн тохирох шошгыг сонгон оруулна. Системд оруулсан гэрэл зураг бүрд тайлбар бичнэ.

8.2.14.Уран сайхны зураг: Дурсгалт газрын болон дурсгалын сайн нягтаршилтай зураг оруулна. GLAM системээр дамжуулан харуулах түүх соёлын хөдлөх дурсгалт зүйлийн уран сайхны зураг байна. (JPEG, PNG) Хэрэв GLAM системд дамжуулах бол GLAM-д дамжуулах цонхийг дарж идэвхжүүлнэ.

8.2.15.Дүрс бичлэг: Дурсгалт газартай холбоотой дүрс бичлэг оруулж болно. Хэрэв GLAM системд дамжуулах бол GLAM-д дамжуулах цонхийг дарж идэвхжүүлнэ.

8.2.16.Тэмдэглэл: Дурсгалын судлагдсан байдал болон судалгааны үр дүнг бичнэ. (судалгаа хийсэн байгууллагын нэр, огноо, үр дүн, хэвлэгдсэн материал г.м). Судлагдаагүй бол судлагдаагүй талаар бичнэ.

8.2.14.Судалгааны цахим файл: Дурсгалын талаарх судалгааны материалыг оруулж болно. Ингэхдээ тайлбар хэсэгт: Дурсгалын талаарх судалгаатай холбоотой цахим файлыг (өгүүлэл, ном г.м) оруулахдаа товчийг дарж гарч ирэх цонхон дахь мэдээллийг бүрэн бөглөж бичнэ.

8.2.15.Яаралтай сэргээн засварлах шаардлагатай эсэх: Дурсгалыг эх төрх байдлыг яаралтай сэргээн засварлах шаардлагатай буюу гэмтэл ихтэй бол "Тийм" гэснийг сонгон тухайн дурсгалд ямар гэтэл байгааг дэлгэрэнгүй бичнэ. Яаралтай сэргээн засварлах шаардлагагүй бол "Үгүй" гэснийг сонгоно.

8.2.16.Сэргээн засварлагдсан эсэх: Дурсгалыг сэргээн засварласан бол "Тийм" гэснийг, сэргээн засварлагдаагүй бол "Үгүй" гэснийг сонгоно.

8.2.17.Сэргээн засварлагдсан байдал: Дурсгал нь сэргээн засварлагдаж байсан бол "Нэмэх" товчийг дарж холбогдох асуулгыг бөглөж мэдээллийг оруулна. Үүнд:

8.2.17.1.тушаал шийдвэрийн дугаар: Удирдах дээд болон эрх бүхий байгууллагын тушаалаар сэргээн засварлагдсан бол тушаалын дугаарыг бичнэ;

8.2.17.2.тайлангийн дугаар: Бүртгэл, мэдээллийн санд хадгалагдаж буй сэргээн засварласан тухай ажлын тайлангийн дугаарыг бичнэ;

8.2.17.3.сэргээн засварлалт хийгдсэн газар: Дурсгалын байрлах унаган газар дээр эсвэл зөөж шилжүүлэн сэргээн засварласан бол аль тохирохыг бичнэ;

8.2.17.4.эхэлсэн огноо: Сэргээн засварлалт эхэлсэн хугацааг бичнэ;

8.2.17.5.дууссан огноо: Сэргээн засварлалт дууссан хугацааг бичнэ.

8.2.17.6.сэргээн зассан тоо ширхэг: Сэргээн засварласан дурсгалын тоо ширхийг бичнэ;

8.2.17.7.сэргээн засварлалтын төрөл: Сэргээн засварлалт хийсэн байгууллагыг сонгоно;

8.2.17.8.сэргээн засварлалтын хэлбэр: Эх төрх байдлыг сэргээн засварласан, Бэхжүүлэлт хийсэн, Цэвэрлэгээ хийсэн, Нөхөлт хийсэн аль тохирохыг сонгоно;

8.2.17.9.**тайлбар:** Сэргээн засварласантай холбоотой бусад мэдээллийг бичнэ;

8.2.17.10.**хавсралт файл:** Дурсгалыг сэргээн засварлан тайлан, болон баримт бичгийг файл (pdf өргөтгөлөөр) хэлбэрээр оруулна;

8.2.18.**Тооллогод хамрагдсан эсэх:** Соёлын өвийг хамгаалах тухай хуульд заасны дагуу түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тооллогод хамрагдсан бол "Тийм" гэснийг, тооллогод хамрагдаагүй бол "Үгүй" гэснийг сонгоно;

8.2.18.1.**дэлгэрэнгүй мэдээлэл:** Дурсгалд ямар төрлийн гэмтэл байгааг мөн тооллогын үеийн мэдээллийг бичнэ;

8.2.18.2.**тооллогод хамрагдсан огноо:** Тооллогод хамруулсан огноо эсвэл тооллогод хамрагдаж байгаагүй бол хадгалалт хамгаалалтын үнэлгээ хийсэн огноог оруулна;

8.2.18.3.**гэмтлийн мэдээлэл:** Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын төрөл зүйл тус бүрд тохирох гэмтлийн асуулгыг тохирох хувиар газар дээр нь үнэлсэн үнэлгээг оруулна. Үнэлгээг 7.20.3 дахь асуулгын дагуу үнэлнэ.

8.3.Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тайлан

8.3.1.**Шинээр бүртгэгдсэн түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тоон дүн:** Шинээр буюу он онд бүртгэгдсэн түүх, соёлын үл хөдлөх дурсгал болон дурсгалт газар нь засаг, захиргааны нэгж, төрөл зүйл, нэр тус бүрээр жагсаалт байдлаар гарна.

8.3.2.**Ашиглалт, эзэмшигч өөрчлөгдсөн түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тоон дүн:** Гэрээгээр эзэмшүүлсэн түүх, соёлын үл хөдлөх дурсгал болон эзэмшигч өөрчлөгдсөн түүх, соёлын үл хөдлөх дурсгал нь засаг, захиргааны нэгж, төрөл зүйл, нэр тус бүрээр жагсаалт байдлаар гарна.

8.3.3.**Хадгалалт, хамгаалалтын нөхцөлийг сайжруулсан дурсгалын тоон дүн:** Эх төрх байдлаар сэргээн засварласан, цэвэрлэгээ хийсэн, хашаа хайс барьсан, иргэн аж ахуй нэгж гэрээгээр хариуцсан болон эрх бүхий байгууллагын шийдвэрээр зөөж шилжүүлсэн түүх, соёлын үл хөдлөх дурсгал нь засаг, захиргааны нэгж, төрөл зүйл, нэр тус бүрээр жагсаалт байдлаар гарна.

8.3.4.**Хадгалалт, хамгаалалтын нөхцөл муудсан түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тоон дүн:** Он онд гэмтсэн, тоногдсон, зөөгдсөн болон алга болсон түүх, соёлын үл хөдлөх дурсгал нь засаг, захиргааны нэгж, төрөл зүйл, нэр тус бүрээр жагсаалт байдлаар гарна.

8.3.5.**Засаг захиргааны нэгж өөрчлөгдсөн түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тоон дүн:** Бүртгэснээс хойш засаг, захиргааны нэгжийг

өөрчилсэн түүх, соёлын үл хөдлөх дурсгал нь засаг, захиргааны нэгж, төрөл зүйл, нэр тус бүрээр жагсаалт байдлаар гарна.

Ес. Баримтат өвийн дэд системд бүртгэл хөтлөх

9.1. Баримтат өвийн бүртгэл нь өмчлөгч, эзэмшигчийн мэдээлэл, үндсэн мэдээлэл, дэлгэрэнгүй мэдээлэл, медиа мэдээлэл гэсэн хэсгээс бүрдэнэ.

9.1.1. **УНБ Сангийн дугаар:** Энэ дугаарыг зөвхөн бүртгэл хийж баталгаажуулсны дараа систем автоматаар өгнө. Баримтат өвийн УНБ Сангийн дугаар нь БӨ0000000 байна. (БӨ- Баримтат өв, 7 орон тоо нь улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд бүртгэгдсэнийг тус тус заана)

9.1.2. **Өмчийн хэлбэр:** Баримтат өвийн өмчлөлийн хэлбэрээс хамаарч төрийн, орон нутгийн, шашны, олон нийтийн, хувийн хэвшлийн, иргэний гэсэн сонголтоос тухайн хуулийн этгээд, иргэн тохирохыг сонгоно.

9.1.3. **Өмчлөгч:** Баримтат өвийн өмчлөлийн хэлбэрээс төрийн, орон нутгийн, шашны, олон нийтийн сонгосон тохиолдолд өмчлөгч нь Монгол Улс гэж автоматаар сонгогдоно. Харин хувийн хэвшлийн, иргэний гэсэн сонголтыг сонгосон бол иргэн, хуулийн этгээдийн нэрийг бичнэ.

9.1.4. **Эзэмшигч:** Төрийн өмч бол тухайн хуулийн этгээдийн нэр, регистр, иргэн бол тухайн эзэмшигч иргэний овог нэр регистрийн дугаар байна.

9.1.5. **Музейн зэрэглэл:** Зааврын 9.1.2. дахь хэсэг өмчийн хэлбэр сонголтоос Төрийн болон орон нутгийн өмчийн гэсэн сонголтыг сонгосон тохиолдолд аль тохирох зэрэглэлийг сонгоно.

9.1.6. **Баримтат өвийн нэр:** Гараас оруулна. Нэр бүтэн байна хэрэв тэмдэгт хэтэрвэл хураангуй нэр байж болно.

9.1.7. **Хувийн дугаар:** Төрийн болон орон нутгийн өмчийн, хувийн музей, байгууллага "Музейн үзмэр, эд өлгийн зүйлийн ерөнхий бүртгэл"-д бичигдсэн "Үзмэр, эд өлгийн зүйлийн хувийн дугаар"-ыг, шинээр бүртгэсэн бол сан хөмрөгт авсан он, музейн захирлын шийдвэрийн дугаар, тухайн шийдвэрт заасан дэсийн дугаар бүхий хувийн дугаарыг бичнэ. Иргэн өөрсдийн бүртгэлийн дугаарыг бичнэ.

9.1.8. **Баримтат өвийн жагсаалтын төрөл:** Дэлхийн өв, бүс нутгийн өв, бүртгэгдээгүй гэсэн сонголтоос сонгоно.

9.1.9. **Үндэсний өвийн жагсаалтад бүртгэгдсэн эсэх:** Сонгох (Шийдвэр нотолгоо гараас оруулна. "Тийм", "Үгүй" гэсэн сонголтоос аль тохирохыг сонгоно. Хэрэв "Тийм" гэсэн сонголтыг сонгосон тохиолдолд үндэсний өвийн жагсаалтад бүртгэгдсэн тушаал шийдвэрийг бичнэ.

9.1.10. **Төрөл зүйл:** Баримтат өвийн 17 төрөл зүйлээс аль тохирохыг сонгоно.

9.1.11. **Тоо ширхэг:** Баримтат өвийн тоо ширхэг бичнэ.

9.1.12. **Иж бүрдлийн бүрэлдэхүүн хэсгийн тоо ширхэг:** Тухайн баримтат өв олон хэсгээс бүрдэж байгаа бол иж бүрдэл бүрийн тоо, ширхгийг бичнэ.

9.1.13. **Эх бүтээл:** Тухайн баримтат өвийн эх бүтээл болон хуулбар болохыг ялган “Тийм”, “Үгүй” гэсэн сонголтыг хийнэ.

9.1.14. **Ховор, түгээмэл байдал:** Баримтат өвийн ховор, түгээмэл байдлыг харгалзан “Нэн ховор”, “Ховор”, “Түгээмэл” сонголтоос тохирохыг сонгоно.

9.1.15. **Ашиглалтын байдал:** Үзүүллэгт, сан хөмрөгт, хувь цуглуулга эсэхийг сонгоно.

9.1.16. **Ерөнхий хэмжээ:** Баримтат өвийн хамгийн ерөнхий өндөр, өргөн /урт/, зузаан, голч, жинг, дурсгалын деталь хэсгүүдийн хэмжээг бусад хэмжээс хэсэгт бичнэ.

9.1.17. **Материал:** Баримтат өвийн үндсэн материалыг аль тохирохыг сонгох ба сонголтод байхгүй материалаар хийсэн тохиолдолд бусад гэсэн сонголтыг сонгоно.

9.1.18. **Товч тодорхойлолт:** Шинээр бүртгүүлж буй баримтат өвийн ач холбогдолтой, эсэх, үнэнхүү хосгүй гайхамшигтай, юугаар ч орлуулшгүй бүтээл гэдгийг нотлон тогтоосон зэргийг бичнэ. Үүнд: Цаг хугацаа, газар нутаг, орон зай, ард түмэн, хүмүүс, агуулга болон сэдэв, ур хийц, төрөл хэлбэр болон хэв маяг, нийгмийн, оюун санааны ач холбогдлыг тодорхойлно.

9.1.19. **Олон нийтэд зориулсан тайлбар:** Баримтат өвийн мэдээллийг бүтэн оруулж дууссаны дараа бөглөх ёстой. Баримтат өвийн мэдээлэл аль болох сонирхолтой бөгөөд энгийн олон нийтэд ойлгомжтой байхаар бичих ба үргэлжлүүлэх товчийг дарснаар олон нийтэд харагдахад бэлэн болно.

9.1.20. **Монголд болж байсан нийгмийн болон соёлын томоохон өөрчлөлтүүдийн ямар цаг үеийн ямар дурсамжийг илтгэн харуулсан бэ?:**

Түүхэн онцгой үйл явдал, шинэ нээлт, хөгжил дэвшил, ухралт доройтлын талаар ямар мэдээ мэдээлэл агуулж байна вэ? гэдгийг энэ хэсэгт бичнэ.

9.1.21. **Монголын төр, улс, нийгмийн харилцааны талаарх дүр төрхийг дүрслэн бичсэн үү?:**

Мөн нөлөө бүхий түүхэн хувь хүн, хүмүүс, хотууд, үндэстэн угсаатан, нийгмийн бүлгүүдийн хэв маягийг тусгасан уу? Агуулга нь байгаль, нийгэм, хүмүүнлэгийн ухаан, улс төр, үзэл суртал, спорт, урлаг дахь түүхэн болоод оюун санааны хөгжил дэвшлийг илтгэн харуулсан уу? гэдгийг бичнэ.

9.1.22. **Баримтат өв бий болж үүссэн нийгэм болоод соёлын орчин нөхцөл нь тэр үеийн газар нутаг, хүмүүсийн төрх байдал, амьдралын**

хэв маяг, соёл зан заншил, жендер, үйлдвэрлэл, урлаг болоод улс төр хөгжиж байсан чухал талуудыг тусгасан уу?:

Монгол Улс, аймаг орон нутгийн байгалийн болон түүхэн газар нутаг, уул, овоо, гол мөрөн, тухайн бүс нутагт болсон түүхэн үйл явдал, барилга архитектурын дурсгал зэргийг тэмдэглэсэн, дүрсэлсэн дурсгалын төрөл зүйл, эд өлгийн зүйлийг хамаатуулан бичнэ.

9.1.23.Нэр дэвшүүлж буй өвийн түүх нь бичиг соёлын өвийн ердийн болон хамгийн сайн үлгэр загвар мөн үү?:

Устаж үгүй болсон юм уу, үгүй болж байгаа мэдээллийн тээгч болон хэв загварын ердийн болон хамгийн сайн жишээ байж чадах уу? гэдэг асуулгуудад тус тус хариулж бичнэ.

9.1.24.Бүртгэн баримтжуулалтын гэрэл зураг: Баримтат өвийн бүртгэх, баримтжуулах, тооллогоор авсан гэрэл зургийг оруулна. Гэрэл зураг оруулахдаа зураг оруулах товчийг дарж гарч ирэх цонхон дахь мэдээллийг бүрэн бөглөж гэрэл зургийн тохирох шошгыг сонгон оруулна.

9.1.25.Уран сайхны гэрэл зураг: GLAM системээр дамжуулан харуулах баримтат өвийн уран сайхны зургийг оруулна. (JPG, PNG) Гэрэл зураг оруулахдаа зураг оруулах товчийг дарж гарч ирэх цонхон дахь мэдээллийг бүрэн бөглөж гэрэл зургийн тохирох шошгыг сонгон оруулна.

9.1.26.Дүрс бичлэг: Түүх соёлын хөдлөх дурсгалт зүйлийн холбогдолтой дуу дүрс бичлэг, контентыг оруулна. Дүрс бичлэг оруулах товчийг дарж гарч ирэх цонхон дахь мэдээллийг бүрэн бөглөж тухай бичлэгийн тохирох шошгыг сонгон оруулна.

9.2.Баримтат өвийн тайлан

9.2.1.Жагсаалтын төрлөөр: Тухайн баримтат өвийг Дэлхийн өв (Олон улс), бүс нутгийн өв болон бүртгэгдээгүй гэсэн тоон үзүүлэлтийг графикаар гаргана.

9.2.2.Төрөл зүйлээр: Системд бүртгэгдсэн баримтат өвийг Дэлхийн өв (Олон улс)-ийн жагсаалт, Бүс нутгийн жагсаалт, Үндэсний жагсаалтад бүртгэгдсэн эсэхийг төрөл зүйлийн тоон үзүүлэлтийг гаргана.

9.2.3.Нийт өмчлөгч, эзэмшигчийн төрөл зүйлийн тоон дүн: Системд бүртгэгдсэн баримтат өвийн тоон үзүүлэлтийг өмчлөгч, эзэмшигч, төрөл зүйлээр гаргана.

9.2.4.Нийт төрөл зүйлийн тоон дүн/аймаг, сум/: Системд бүртгэгдсэн баримтат өвийн төрөл зүйлийг засаг, захиргааны нэгжээр гаргана.

9.2.5.Ховор түгээмэл байдал: Системд бүртгэгдсэн баримтат өвийн хувийг нэн ховор, ховор, түгээмэл гэсэн үзүүлэлтээр график байдлаар гаргана. Дээрх тайлангийн үзүүлэлт тус бүрийг эхлэх, дуусах огноог оруулан шүүлт хийж гаргаж болно.

9.3.Баримтат өвийн файл

Энэ хэсэг төрийн болон орон нутгийн музей, байгууллага, иргэн, аж ахуй нэгжээс ирсэн жагсаалтыг хадгална. Энэхүү хэсэгт зөвхөн Соёлын өвийн үндэсний төвийн баримтат өв хариуцсан бүртгэл, мэдээллийн санч файл оруулах, харах эрхтэй байна.

---oOo---